

ГАРЧИГ

| | |
|---|---------------------------------------|
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | 3 |
| ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР | 4 |
| ОРШИЛ..... | 5 |
| ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ | 6 |
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ | 14 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ..... | 21 |
| 2.1. Төслийн ерөнхий мэдээлэл | 21 |
| Төслийн нэр: | “Тэрэлж лож” жуулчны бааз төсөл 21 |
| 2.2. Төслийн зорилго..... | 21 |
| 2.3. Төслийн байршил..... | 21 |
| 2.2. Төслийн төлөвлөлт, хүчин чадал | 23 |
| 2.3. Төслийн технологи, үндсэн үйл ажиллагаа | 37 |
| 2.4. Түүхий эд, туслах материал..... | 38 |
| 2.4.1. Ус хангамж, хэрэглээ..... | 38 |
| 2.4.2. Цахилгаан эрчим хүчний хангамж..... | 41 |
| 2.4.3. Дулаан хангамж..... | 42 |
| 2.5. Хог хаягдал..... | 42 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ..... | 49 |
| 3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл..... | 49 |
| 3.2. Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл..... | 50 |
| 2.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл | 52 |
| 2.4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл | 53 |
| 2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл..... | 53 |
| 2.6. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл..... | 54 |
| 2.7. Төслөөс үзүүлэх бусад нөлөөлөл | 55 |
| 2.8. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим | 56 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ | 58 |
| 4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | 58 |
| 4.2. Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | 58 |
| 4.3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ ... | 59 |
| 4.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ | 60 |
| 4.5. Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж..... | 63 |
| 4.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 64 |
| 4.7. Ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ..... | 65 |
| 4.8. Үйлчилгээний соёлч байдал, эрүүл ахуйн зөвлөмж | 66 |
| ТАВДУГААР БҮЛЭГ.ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ..... | 67 |

| | | |
|------|---|-----------|
| 1.1. | Хүний эрүүл мэндэд харшилж болзошгүй нөлөөлөл..... | 68 |
| 1.2. | Байгаль-экологийн тэнцвэрийг алдагдуулж болзошгүй нөлөөлөл..... | 69 |
| 1.3. | Байгалийн гамшигт үзэгдлийн гаралтай эрсдлийн үнэлгээ..... | 70 |
| 1.4. | Төслийн техник технологиос үүдэлтэй эрсдэл..... | 72 |
| | ЗУРГААДУГААРБҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 74 |
| 6.1. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ | 74 |
| 6.2. | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 75 |
| 8.2. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 80 |
| | ДҮГНЭЛТ | 82 |
| | АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ | 83 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | | |
|-----------|---|----|
| Зураг 1. | “Тэрэлж лож” жуулчны баазын байршлын тойм зураг | 22 |
| Зураг 2. | “Тэрэлж лож” жуулчны баазын харагдах байдал | 23 |
| Зураг 3. | “Тэрэлж лож” жуулчны баазын газар ашиглалтын зураг..... | 24 |
| Зураг 4. | Өргөтгөхөөр төлөвлөж буй талбай..... | 25 |
| Зураг 6. | Люкс гэр..... | 26 |
| Зураг 7. | Люкс гэрийн дотор талын харагдах байдал..... | 26 |
| Зураг 8. | Люкс гэрийн 00, Дүш | 27 |
| Зураг 9. | Зуны байшин | 28 |
| Зураг 10. | Зуны байшингийн дотор тал..... | 29 |
| Зураг 11. | Цомцог гэрийн харагдах байдал | 29 |
| Зураг 12. | Цомцог гэрийн дотоод байдал..... | 30 |
| Зураг 13. | Явган хүний замыг тохижуулсан байдал..... | 31 |
| Зураг 14. | “Өв соёл” ресторан | 32 |
| Зураг 15. | Монгол гэр ресторан, гэр лаунж..... | 32 |
| Зураг 16. | Ажилчдын амралтын байр..... | 33 |
| Зураг 17. | Төслийн талбай дахь сагсан бөмбөг, хүүхдийн тоглоомын талбай..... | 34 |
| Зураг 18. | Музей гэр (үйл ажиллагаа явуулж эхлэх үедээ барьдаг) | 35 |
| Зураг 19. | Ногоон байгууламж, сүүдрэвч | 36 |
| Зураг 20. | Нийтийн бие засах газар..... | 37 |
| Зураг 21. | “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын гүний худаг | 40 |
| Зураг 22. | Ажилчдын байрны ус нөөцлүүрийн сан | 41 |
| Зураг 23. | Жуулчны баазын КТПН..... | 42 |
| Зураг 24. | Жуулчны баазын хатуу хаягдлын түр цэгийн өнөөгийн байдал..... | 43 |
| Зураг 25. | Төслийн талбайд байрлуулсан хогийн сав | 44 |
| Зураг 26. | Хуванцар сав хаях хогийн савны загвар..... | 45 |
| Зураг 27. | Бохирын цооног..... | 47 |
| Зураг 28. | “Тэрэлж лож” жуулчны баазын ашиглаж буй соруулдаг нүхэн жорлон | 48 |
| Зураг 29. | Агаарын дээж авч буй байдал..... | 49 |
| Зураг 30. | Нөлөөллийн үргэлжлэх хугацаа ба хэлбэр..... | 57 |
| Зураг 31. | Төслийн үйл ажиллагааны явцад илрэх эерэг ба сөрөг нөлөөллийн эзлэх хувь..... | 57 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал (2022-2026)..... | 13 |
| Хүснэгт 2. Монгол улсын хууль тогтоомж | 14 |
| Хүснэгт 3. Улсын их хурлын тогтоол | 16 |
| Хүснэгт 4. Монгол улсын Засгийн газрын тогтоол | 16 |
| Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаатай холбоотой зарим тогтоол шийдвэр, дүрэм журам, заавар, аргачлал..... | 17 |
| Хүснэгт 6. Төслийн хүрээнд ашиглагдах стандартууд | 17 |
| Хүснэгт 7. Төслийн хүрээнд баримталж ажиллах байгаль орчны зарим дүрэм, журмууд .. | 20 |
| Хүснэгт 8. Төслийн талбайн координат..... | 21 |
| Хүснэгт 9. Жуулчны баазын газар ашиглалт | 24 |
| Хүснэгт 10. Төслийн хүчин чадал | 25 |
| Хүснэгт 11. Усны тооцоо | 39 |
| Хүснэгт 12. Гүний худгийн усны шинжилгээний үзүүлэлтүүд..... | 39 |
| Хүснэгт 13. Агаарын чанарын нөлөөллийн шинжилгээний матриц | 50 |
| Хүснэгт 14. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц..... | 51 |
| Хүснэгт 15. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц..... | 52 |
| Хүснэгт 16. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц | 53 |
| Хүснэгт 17. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц..... | 54 |
| Хүснэгт 18. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц | 55 |
| Хүснэгт 19. Төслөөс үзүүлэх бусад нөлөөллийн шинжилгээний матриц..... | 56 |
| Хүснэгт 20. УРГАМАЛ ТАРИАЛАХ ХУГАЦАА | 61 |
| Хүснэгт 21. УРГАМЛЫН ҮРИЙН НОРМ..... | 62 |
| Хүснэгт 22. Салхины хурдаас хамаарч үүсэх нөлөөлөл | 71 |
| Хүснэгт 23. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө..... | 75 |
| Хүснэгт 24. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв, мян.төг | 80 |
| Хүснэгт 25. Орчны хяналт шинжилгээ..... | 81 |

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

| | |
|---------|--|
| БОННУ | -Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ |
| БОТБУ | -Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ |
| БОМТ | -Байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| ТЖБОМТ | -Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| ОХШХ | -Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |
| БОАЖЯ | -Байгаль орчин аялал жуулчлалын яам |
| БОНХС | -Байгаль орчин ногоон хөгжлийн сайд |
| БОНХАЖС | -Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын сайд |
| БОАЖС | -Байгаль орчин аялал жуулчлалын сайд |
| АЧС | -Агаарын чанарын стандарт |
| ЗДХ | -Зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| ЗДА | -Зөвшөөрөгдөх дээд агууламж |
| ХЭМЭҮ | -Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ |
| БОЭҮ | -Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ |
| ОАЭҮ | -Осол аюулын эрсдэлийн үнэлгээ |
| ХХАА | -Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа |



ОРШИЛ

“ПЛАНЕТ ИНТЕРНЭШНЛ” ХХК хэрэгжүүлж буй жуулчны бааз төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээ болон БОАЖЯ-ны 2021 оны 12-р сарын 20-ны өдрийн 2021/Б-112 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан “Хос нахиа” ХХК боловсрууллаа.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын гол зорилго нь тус төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд учруулж болзошгүй гол нөлөөлөл, цаашид учруулж болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээний зөвлөмж болон тухайн төслийг хэрэгжүүлэх явцад мөрдөж ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах явдал юм.

Энэ хүрээнд “Тэрэлж лож” аялал жуулчлалын бааз төслийн БОННУ-ний нэмэлт тодотголын тайланг Монгол улсын үндсэн хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль(2012 он), Байгаль орчны бусад хууль тогтоомжууд, түүнтэй холбогдон гарсан дүрэм журам, МУ-ын БОНХСайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын дагуу шинжээчдийн багийг бүрдүүлэн доорхи ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

Тус төслийн үйл ажиллагааны явцад тухайн орчны байгалийн унаган төрх алдагдах, ялангуяа төслийн барилга байгууламж барих, зам талбайг тавих зэрэг бүтээн байгуулалтын ажлын үе шатанд тухайн газрын хөрс эвдрэх, түүний хамт ургамлан нөмрөг устгах, тус төслийн цаашдын үйл ажиллагаа, үйлчилгээний явцад хатуу, шингэн хог хаягдлыг стандартын дагуу цуглуулж, зайлуулаагүйн улмаас хөрс, газрын доорх ус бохирдох, машин техник, хүний хөл хөдөлгөөнөөр олон салаа зам, жим гарч ургамлан нөмрөгийг талхлан доройтуулж, хөрсөн бүрхэвчийг элэгдэлд оруулах, төслийн үйл ажиллагаа, машин техник, хүний хөл хөдөлгөөн, дуу чимээнээс тухайн орчны шувуу, амьтад үргэж дайжин тархац байршил нутаг нь алдагдах зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй байгааг тодорхойлсон бөгөөд тэдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ болон болзошгүй аюул осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, багасгах, арилгах арга хэмжээний талаар тус тус тодорхой тусгасан болно.

Тус төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргийг холбогдох зардлын хамт боловсруулав. Харин тус төслийн цар хүрээ, үйл ажиллагаа, байршил зэрэгтэй холбоотойгоор биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй байлаа.

Цаашид, төсөл хэрэгжүүлэгч энэхүү тайланд тусгагдсан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, бусад төлөвлөгөө болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах шаардлагатай болно.

БОННУ-ний тайлан нь нийт 6 бүлэг, 84 хуудастай бөгөөд төслийн орчны зураг болон холбогдох бусад хавсралт материалуудтай болно.

ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

НЭГ. Төслийн төлөвлөлтийн тухай

“Тэрэлж лож” жуулчны бааз төсөл нь засаг захиргааны хувиарлалтаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн БЦГ-ын Онгоцотын аманд байрлах бөгөөд нийт 9.5 га талбайд нь 2005 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус жуулчны бааз нь Улаанбаатар хотоос 56 км-ийн зайтай Өвөр Горхийн голын хөндийн баруун талд Хэнтийн нурууны дундаж өндөртэй Дүнхэн, Номт уулын урд энгэрт байрладаг.

“Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын нийт эдэлбэр газрын хэмжээ нь 9.5 га талбайтай бөгөөд дотроо А, В гэсэн хоёр хэсэгт хувааж болно. А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.23 га, В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га талбайг тус тус эзлэнэ.

Жуулчны баазад байгаль орчны нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол хийх үед Ариун цэврийн өрөө, угаалгын өрөө тусдаа байрлах Люкс гэр 16, шалны халаалттай, орчин үеийн байдлаар баригдсан Цомцог гэр 28, зуны байшин 10, Өв соёл ресторан, гэр ресторан, гэр лоунж, гэр музей, сагсан бөмбөгийн гадаа талбай, элсний волейболын талбай, хөл бамбагийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, гадаа агаарлах террас 2-тойгоор үйл ажиллагаа явуулдаг. Нийт 16 люкс гэр 2 ортойгоор 64 хүн, 28 цомцог гэр 4 ортойгоор 112 хүн, 10 зуны байшин 2 ортойгоор 40 хүнийг хамгийн ихдээ хүлээн авах ба нийтдээ нэг дор 216 хүнийг хүлээн авах хүчин чадалтай.

Ресторан дотор талаасаа 60-70 хүн хүлээн авах чадал бүхий заалттай. Гэр ресторан 40, гэр лоунж 30 хүнийг хүлээн авах ба нийт 140 хүнийг хүлээн авах чадалтай.

“Планет интернэшнл” ХХК-ийн “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын газар ашиглах зөвшөөрөлтэй талбай нь 2 хэсэг газраас бүрдэх ба нийт 9.5 га байна. Одоогийн байдлаар амрагчид байрлах байшин барилга 3.025.02 м², явган хүний зам 1.544.33 м², ногоон байгууламж 806.77 м², авто зогсоол 1.473.83 м², агуулах, саравч 290.6 м², бохирын цооног 44.78 м², өнгөт хавтангаар тохижуулсан талбай 75.06 м², тоглоомын талбай 2.492.66 м², биеийн тамирын талбай 718.91 м², хувцас хатаах талбай 252.08 м² талбайг тус тус эзэлж байна.

Тэрэлж Лож жуулчны баазын нийт эдэлбэр газар нь ойт хээрийн бүсэд 5-10⁰-ын хэвгийтэй энгэр хажуу уулын бэлд байрлах ба нийт эдэлбэр газрын хэмжээ нь 9.51 га буюу 95 100 м² талбайтай бөгөөд дотроо А, В гэсэн хоёр хэсэгт хувааж болно. А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.25 га буюу 62 500 м², В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га буюу 32 600 м² талбайг тус тус эзлэнэ.

А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.25 га буюу 62 500 м² талбайн 5.49 га буюу 54930.6 м² талбайн хөрс, ургамал ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй. Үлдсэн 7569.4 м² буюу 0.76 га талбайд аялал жуулчлалын амралт, баазын үйл ажиллагааны чиглэлээр ашиглагдаж байна. В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га буюу 32 600 м² талбайн 3.14 га буюу 31423.1 м² талбайн хөрс, ургамал ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй бөгөөд энэ талбайд жуулчидад зориулсан “Эрийн гурван наадам” зохион байгуулдаг. Үлдсэн 1176.9 м² буюу 0.12 га талбайд аялал жуулчлалын амралт, баазын үйл ажиллагааны чиглэлээр ашиглагдаж байна.

Нийт эзэмшил талбайн 90.7 % нь ямар нэгэн газар ашиглалт явагдаагүй хөрс, ургамлын эвдрэлгүй, байгаль орчны сөрөг нөлөөлөл байхгүй. Тус баазын газар ашиглалтын зургаас харахад баазын газрын нөөц арвинтай мөн газар ашиглалтын тохиромжтой

хэлбэрүүдийг сонгон ашиглаж, хөрс, ургамлын доройтол, бохирдлоос урьчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нь харагдаж байна.

Төслийн идэвхитэй үйл ажиллагааны үед нийт 20-30 хүн ажилладаг байна. Ажилчдыг амралтын газарт байрлах ажилчдын байранд байрлуулдаг.

Уг төслийн үндсэн үйл ажиллагаа нь амрагч, аялагчдыг хүлээн авч, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан тав тухтай орчинд амраах, аяллын хөтөлбөрт хамруулах, үйлчилгээ үзүүлэх, амрагчдыг үдэх гэсэн үе шат дарааллаар явагдана.

Тэрэлж Лож жуулчны бааз нь унд ахуй, үйлчилгээний зориулалтаар 2014 онд зохих зөвшөөрлийн хүрээнд Ус Оюу ХХК-иар өөрсдийн эзэмшил талбайдаа 45 мн гүнтэй гүний худаг гаргуулжээ. 2016 оны 8-сард гаргасан нийслэлийн БОНХГ-аар ус ашиглуулах дүгнэлтээр тус худгийн насос нь 10 м³/цаг хүчин чадалтай, 128 м напортай бөгөөд хоногт 155.52м³ ус ашиглах боломжтой. Зуны жуулчдын идэвхитэй үеэр хоногт дунджаар 36.34 м³ ус ашиглаж байна. Мөн 2020 оны 8-р сарын 02-ны өдрөөс 2022 оны 8-р сарын 02 хүртэлх ус ашиглах Дугаар 2021/10 тоот гэрээг Налайх дүүргийн ЗДТГ-тай хийсэн байна.

Харин худгийн шугам дээр 2014 оны 03 дугаар сард суурилуулсан LXSGR-32 загварын, 00226 дугаартай, 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 05875 м³ заалт бүхий усны тоолуурыг шинэ тоолуураар солисон байна. Стандарт, хэмжил зүйн газрын баталгаажуулсан LXSGR-32 загварын, 2004039814 дугаартай, 00000 м³ заалттай усны тоолуурыг 2020 оны 05 дугаар сарын 23-ны өдөр суурилуулсан.

“Тэрэлж лож” жуулчны бааз нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-тай байгуулсан “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-ний дагуу төвлөрсөн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдон үйл ажиллагаа явуулж байна.

Жуулчны бааз нь зуны улиралд 4 сарын хугацаатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2021 онд Байгаль орчинд ээлтэй шалны халаалтаар дулаанаа шийдсэн бөгөөд зочин хүсвэл нүүрсний агууламжгүй шахмал модон түлшээр галлаж халаах боломжтой.

“Тэрэлж лож” амралт, аялал жуулчлалын цогцолбор төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болон талбайн орчимд дуу чимээ, доргио чичиргээ, цацраг идэвхит бодисын эх үүсвэрүүд зэрэг физик бохирдол, хог хаягдлын эх үүсвэрүүд байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагаанаас ахуйн хатуу шингэн хог хаягдал гарна.

Уг амралтын газар нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед хоногт 60-100 хүн хүлээж авах ба нийт ажилчдын тоо нь 20 байх тул нэг хүний ахуйн хэрэглээнээс үүсэх хатуу хаягдлын хэмжээг дунджаар 1.5 кг, нийт хатуу хаягдал үүсгэх хүнийг тоог 100 байхаар тус тус тооцож ахуйн хэрэглээнээс үүсэх хатуу хог хаягдлын хэмжээг тодорхойлоход хоногт дунджаар 0.15 тн буюу 150 кг орчим хатуу хог хаягдал гарахаар байна. Гэхдээ энэ нь үйл ажиллагаа явуулах буюу жил бүрийн 5-р сарын 1 ээс 9-р сарын 1-ны хугацаанд энэ хэмжээгээр гарна гэж үзэх нь зүйтэй. Харин бусад үед ажиллахгүй тул хатуу хаягдал үүсэхгүй.

Шингэн хаягдлын үүсэх хэмжээг нийт ус хэрэглээний 70%-иар тооцдог. Төслийн идэвхитэй үйл ажиллагааны үед хоногт 36.34 м³ ус хэрэглэх тул үүсэх шингэн хаягдал нь 25.43 м³/хоног байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь ахуйн шингэн хаягдлыг бохирын шугам хоолойгоор дамжуулан бохирын цоногт хуримтлуулж “Маргад эрдэнэ” ХХК-тай байгуулсан хэрэглээнээс гарсан шингэн хог хаягдал зөөвөрлөх Бохир ус тээвэрлэлтийн гэрээний дагуу 16 хоногт 1 удаа соруулан зайлуулж байна.

Төслийн талбайд нийтийн 10 ширхэг 00, 16 ширхэг душ, 15 ширхэг угаалтуур бүхий ариун цэврийн өрөөнд мөн хүүхдэд зориулсан намхан угаалтуур, суултуур байрлуулсан байна. 2020 онд байгаль орчинд ээлтэй цахилгаан халаагууртай болгосон.

Хоёр. Төсөл хэрэгжих орчны байгаль, цаг уурын нөхцөл

Физик газарзүйн онцлог

“Тэрэлж лож” жуулчны бааз төсөл хэрэгжиж буй Горхи-Тэрэлжийн БЦГ нь Улаанбаатараас зүүн тийш 50-76 км зайд орших байгалийн үзэсгэлэн бүрдсэн газар бөгөөд хад асга бүхий уулын тогтоцоороо өвөрмөц бүс юм. Төслийн талбай нь 5-18хэмийн налуу гадаргад, далайн түвшнээс дээш 1527-1567 м-ийн өндөрт, Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлалаар хөрсний оргил хурдатгал (PGA)-143-190 см/с², MSK-64-ын VII баллын бүсэд байрладаг.

Цаг уур, уур амьсгал: Төсөл хэрэгжих газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нэг тэгш хэмийн хуваарилалттай. Хаврын дулааралт намрын сэрүүсэлтийн явц ижилхэн, зун нь сэрүүн чийглэг, өвөл нь хүйтэн чийглэг, уур амьсгалын үзүүлэлт нь хэм тэнцүү хуваарилалттай. Монгол орны бусад нутгаас хамгийн их хур тунадастай, чийглэг, сэрүүн, өвөл нь цасархаг харьцангуй дулаавтар тунгалаг цэнгэг агаартай. Хавар нь хуурайвтар, хахир хахирлаг, намар нь өгөөж баян сэрүүн сэрүүвтэр, үе үе хөрөлтийн буюу цацрагийн манан татаж байдаг.

Гадаргын ус: Тус баазын орчимд гадаргын ил урсац байхгүй бөгөөд баазаас зүүн урагш Өвөр Горхийн гол урсадаг. Харин баазын ойролцоох гуу, жалга, суваг, шуудууг даган урсах хаврын шар усны урсац бүрэлдэх боломжтой бөгөөд энэ урсгал усны хуурай шугаман элэгдлүүд болох гуу, жалгуудыг хаах, хог хаягдал хаявал түүгээр дамжин Өвөр Горхийн голд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Газрын доорх ус: Газрын доорх ус нь Монгол орны хамгийн чухал усны эх үүсвэр юм. Нийгэм, эдийн засгийн бүхий л салбаруудын үйл ажиллагаа газрын доорх усны нөөц, түүний боломжоос шууд хамаардаг. Гадаргын ус байхгүй газруудад малчид гүний худгаас усаа авч ашигладаг.

Тэрэлж Лож жуулчны бааз нь унд ахуй, үйлчилгээний зориулалтаар 2014 онд зохих зөвшөөрлийн хүрээнд Ус Оюу ХХК-иар өөрсдийн эзэмшил талбайдаа 45 мн гүнтэй гүний худаг гаргуулжээ. 2016 оны 8-сард гаргасан нийслэлийн БОНХГ-аар ус ашиглуулах дүгнэлтээр тус худгийн насос нь 10 м³/цаг хүчин чадалтай, 128 м напортой бөгөөд хоногт 155.52м³ ус ашиглах боломжтой. Зуны жуулчдын идэвхитэй үеэр хоногт дунджаар 36.34 м³ ус ашиглаж байна. Мөн 2020 оны 8-р сарын 02-ны өдрөөс 2022 оны 8-р сарын 02 хүртэлх ус ашиглах Дугаар 2021/10 тоот гэрээг Налайх дүүргийн ЗДТГ-тай хийсэн байна.

Хөрсөн бүрхэвч: Горхи-Тэрэлжийн тусгай хамгаалалттай газар нутаг Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар Хэнтийн мужид багтах ба уулын ойн бараан хөрс, уулын хар шороон хөрс, хар шороон хөрст, нугат-хар шороон хөрс, нугын ба нугат-намгийн хүлэрлэг цэвдэгт хөрсний хэв шинжүүд тархсан байна.

Ойн хилээс доош уулсын бэл хормой, хөх чулуутын голын өндөр дэнж зэрэг үетэн-элдэв өвс голлолсон нугат хээрийн ургамалшилтай газарт тархана. Хөрсний зузаан тархсан хотгор гүдгэрийн онцлогоос хамаарч янз бүр байх боловч 20-40 см хооронд хэлбэлзэнэ. Ялзмаг хуримтлалын давхарга тод хар саарал өнгөтэй, өнгөн хэсэгтээ ширэгжсэн, доод хил нь жигд биш ¼ давхарга руу түрж орсон байх нь элбэг. ¼ давхаргын дор делювийн хэмхдэс, сайр чулуутай хөрс үүсгэгч эх чулуулаг оришно. Энэ хөрс үржил шим хамгийн сайнтай байдгаараа онцлог юм. Энд хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөлөл бага бөгөөд ихэнх зам талбайг зориулалтын цементэн зам тавьжээ.

Хээрийн судалгааны ажлын үед төслийн талбай болон түүний ойр орчмын хөрсний гадаргад хатуу хог хаягдал, ундааны сав, чихрийн уут, архины шил, гялгар уут гэх мэт ахуйн хэрэглээний байгальд устдаггүй хөрсөнд шингэдэггүй полимер нэгдлүүдээс бүтсэн хог хаягдлыг ил задгай хаяагүй нь ажиглагдсан боловч дулааны улирал эхэлж үйл ажиллагаа эхлэх үед тухайн орчимд ил задгай хог хаягдаж болзошгүй тул төсөл хэрэгжүүлэгч нь

төслийн талбайн орчны ахуйн хог хаягдлыг байнга цуглуулан цэвэрлэж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх, хяналт тавих шаардлагатай.

Ургамлан нөмрөг: Хэнтийн нурууны ургамал газарзүйн мужлалтаар /А.А.Юнатов, 1950/ тус район дараах тойрогт багтана. Евроазийн шилмүүст ойн мужийн Өвөр Байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрогт багтана. Уулын хээрийн бүслүүрт хуурайсаг олон наст дэгнүүлт ба үндэслэг ишт үетэн, алаг өвслөг ургамал зонхилдог. Хээрийн ургамал зонхилох боловч бусдаас газраас ялгагдах нэг онцлог нь хуурайсаг сөөг болох харгана, агь зэрэг сөөг ба сөөгөнцөр ихтэй байдаг явдал юм. Хэдийгээр уулын хээрт өвслөг ургамал намхан тачир боловч шимт чанараар өндөр. Уулын хээрт лени бортууль (*Festuca lenensis*), далансүүл (*Koeleria macrantha*), дэрвээн дэгд (*Gentiana squarrosa*), хялгана (*Stipa krylovii*) зонхилон ургана. Энэ бүслүүрт хуурайсаг, чийгсүү-хуурайсаг, хуурайсаг-чулуусаг ургамал гол хувийг эзэлж байдаг нь зүй ёсны үзэгдэл юм [34]. Одоогоор төслийн талбайд ховор болон нэн ховор ургамал тэмдэглэгдээгүй бөгөөд баазын баруун талаар багахан хэмжээний шинэсэн ойтой.

Амьтны аймаг:

Тус баазын орчим Горхи-Тэрэлжийн БЦГ нутгийн хүрээнд 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 9 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг. Эдгээрээс тус районд шавьж идэштнээс өөдсөн атигдаахай, бэсрэг царам, дааган, хонин атигдаахай, сарьсан далавчтнаас сахалт, моотон багваахай, туулай хэлбэртнээс чандага, дагуур болон асгадны огдой, мэрэгчдээс жирх, бор туулай, хэрэм, тарвага, сохор номин, махан идэштнээс саарал чоно, шар үнэг, дорго, цагаан үен, туурайтнаас зэрлэг гахай, халиун буга, бор гөрөөс, хандгай зэрэг амьтад үзэгдэнэ.

Төсөл хэрэгжих орчны бохирдол доройтлын өнөөгийн түвшин

Газрын гадарга: “Тэрэлж лож” жуулчны баазын ашиглалтын нийт талбайг А, В гэсэн хэсэгт хувааж болно. А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.25 га буюу 62 500 м² талбайн 5.49 га буюу 54930.6 м² талбайн хөрс, ургамал ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй. Үлдсэн 7569.4 м² буюу 0.76 га талбайд аялал жуулчлалын амралт, баазын үйл ажиллагааны чиглэлээр ашиглагдаж байна. В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га буюу 32 600 м² талбайн 3.14 га буюу 31423.1 м² талбайн хөрс, ургамал ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй бөгөөд энэ талбайд жуулчидад зориулсан “Эрийн гурван наадам” зохион байгуулдаг. Үлдсэн 1176.9 м² буюу 0.12 га талбайд аялал жуулчлалын амралт, баазын үйл ажиллагааны чиглэлээр ашиглагдаж байна.

Нийт эзэмшил талбайн 90.7 % нь ямар нэгэн газар ашиглалт явагдаагүй хөрс, ургамлын эвдрэлгүй, байгаль орчны сөрөг нөлөөлөл байхгүй. Тус баазын газар ашиглалтын зургаас харахад баазын газрын нөөц арвинтай мөн газар ашиглалтын тохиромжтой хэлбэрүүдийг сонгон ашиглаж, хөрс, ургамлын доройтол, бохирдлоос урьчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нь харагдаж байна.

Агаарын чанар:Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрт агаар бохирдуулагч томоохон эх үүсвэр байхгүй байна. Тээврийн хэрэгсэл явах үед боссон замын тоос, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах утаа зэрэг нь агаар орчныг бохирдуулж болзошгүй боловч дээрхи үйл ажиллагаанаас үүсэх тоос болон хийн хаягдал нь орчны агаарын чанарт хүчтэй нөлөө үзүүлэхгүй.

Өмнө хийгдсэн судалгааны материалаас үзэхэд агаарын бохирдлын үзүүлэлтүүд стандартын хүлцэх агууламжаас хэтэрсэн тохиолдол гараагүй байна. Харин агаарт байх хүхэрт нэгдлүүдийн агууламж өчүүхэн буюу 0.008 мг/м³ орчим болоход хоромхон зуур устаж арилдаг Навчраа гадилт (*Parmelia sulcata*) хагууд Горхийн даваанаас эхлэн үргэлжилж 2050 м өндөр Цагаан морьт ууланд элбэг тархсан төдийгүй, 1550 м өндөр Хамбын овооны шинэс

модон дотор хэвийн өсөлттэй үржиж байна. Энэ нь тухайн бүс нутгийн агаар маш цэвэр болохыг харуулж байна.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжиж буй талбайн орчны хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөлөл бага бөгөөд ихэнх зам талбайг зориулалтын цементэн зам тавьжээ.

Гадаргын болон газрын доорх ус: Төслийн талбайд ойрхон гадаргын усан сүлжээ байхгүй тул гадаргын усны чанарын шинжилгээ хийгдээгүй болно. Харин төсөл хэрэгжүүлэгч нь унд ахуйн усны хэрэглээг төслийн талбайд байрлах өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг тул уг гүний худгаас дээж авч газрын гүний усны хяналт шинжилгээг хийлээ. “Тэрэлж лож” жуулчны баазын ундны ус нь шинжлэгдсэн үзүүлэлтийн түвшинд Монгол Улсын “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлагад нийцэж байна.

Гурав. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд

| | |
|---------------------------------------|---|
| Агаар орчин | Төслийн үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага зэрэг эрчимтэй шууд нөлөөлөл байх ба шалны халаалттай тул агаарын чанарт эерэг нөлөө үзүүлнэ. Харин Барилга байгууламж нэмж барих болон авто машин амрагчдын хөл хөдөлгөөн зэргээс богино хугацааны дунд зэргийн сөрөг нөлөө үзүүлэхээр байна. |
| Хөрсөн бүрхэвч, газрын гадарга хэвлий | Төслийн үйл ажиллагаанаас газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөлөл богино хугацаанд дунд зэрэг нөлөөлөл байх ба шинээр барилга байгууламж барих, өргөтгөсний дараагаар эвдэрсэн газрын гадаргыг нөхөн сэргээж ургамалжуулах зэрэг арга хэмжээ авснаар газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл бага болон дунд зэрэг эрчимтэй болзошгүй нөлөөлөл байна. Шинээр барилга байгууламж барих, өргөтгөл хийх нь хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөө үзүүлнэ. |
| Усны нөөц, чанар | Төслийн үйл ажиллагааны үеийн усны хэрэглээг гүний худгийн ус дангаараа хангана. Мөн саарал усаа ашиглахгүй байгаа нь төслийн үйл ажиллагаанаас дунд зэргийн сөрөг нөлөөтэй Төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл нь төдийлөн эрчимтэй бус юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой хэмжээгээр бохирдуулж болзошгүй |
| Ургамал | Баазын доторх явган хүний зам талбайг хатуу хучилттай болгосон нь урт хугацаанд ургамлан нөмрөгт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин шинээр барилга байгууламж барих нь дунд хугацаанд шууд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн амрагчдын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал алдагдаж хөрсөнд тос масло асгарч гоожих зэрэг нь болзошгүй бага зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. |
| Амьтан | Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага зэрэг бөгөөд урт хугацаанд үргэлжилнэ. Төслийн үйл ажиллагааны үед дуу чимээ үүсгэн амьтны аймагт тайван бус нөлөөлөл үүсгэнэ. Мөн төслийн барилгын үйл ажиллагаа явуулж байх үед тус газар нутагт амьдардаг амьтны аймагт дам болон шууд байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй. Ялангуяа машин техникийн зорчих хөдөлгөөн, барилгын үед үүсэн бий болох дуу чимээ, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдаж болзошгүй юм. |

Сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж

- Эдэлбэр газар дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон хүний үйл ажиллагаагаар нэмж элэгдэж, доройтхоос сэргийлэх;
- Хог хаягдлыг шатаах аргаар устгахгүй байх;
- Төв замаас эдэлбэр газар хүртэл нэг замаар явах, замын дагуу 500-1000 м-ийн зайд хаяг, замын тэмдгийг байршуулах, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоолыг байр, сууцнаас 200 м-ээс багагүй зайд байрлуулж тэмдэгжүүлэх, онцын шаардлагагүй үед тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх;
- Цогцолборын орчимд олон салаа зам гаргаж хөрсийг талхлахгүй байх үүднээс үйлчилгээний цэгүүд, аяллын маршрутын зам зэргийг оновчтой төлөвлөн, засч янзлан тохижуулж, шаардлагатай гэж үзвэл бусад зам үүсэх магадлалт хэсгүүдийг хааж ургамлын үр цацаж ургамалжуулах;
- Гал түймрийн аюулаас ямагт сэрэмжилж, урьдчилсан арга хэмжээ төлөвлөх, галын буланг хүний нүдэнд ил харагдахуйц байрлалд байгуулж, галын хор, элсний нөөцийг нэмэгдүүлэх, хүрз, сүх, эсгий зэрэг шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр тоноглох;
- Эргэн тойрны 0.5-1.0 км радиустай газрыг хяналтандаа авч бохирдохоос сэргийлж, тогтмол цэвэрлэж байх, хяналт тавих, шаардлагатай үед амрагчдад шаардлага тавьж болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх;
- Хоногт 50 м³-аас бага ус хэрэглэх тул Нийслэлийн байгаль орчны газраар жил бүр ус ашиглах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулан ажиллах;
- Гүний худгийг бохирдлоос хамгаалах зорилгоор Усны тухай хуулийн 22.3, БОНХАЖСайд болон БХБСайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дах заалтын дагуу ус хангамжийн эх үүсвэр/гүний худаг/-ээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс тогтоож мөрдөж ажиллах;
- Ахуйн бохир усыг биоректорын аргаар цэвэршүүлдэг Герман улсын “MBR” төхөөрөмжийг суурилуулан цэвэршүүлэх, уг төхөөрөмжөөр цэвэршүүлсэн саарал усыг төслийн талбайн орчны зүлэг ногоон байгууламж, зам талбайг услахад ашиглах;
- Ашиглалтын үед гарах тоосжилтыг бууруулах үүднээс байгаль хамгаалах төлөвлөгөөнд заагдсан хугацаа, давтамжаар орчны агаар, хөрсийг чийгшүүлж байх;
- Автомашин, техникүүдийн янданд байрлах оч баригчуудыг сайтар шалгах. Ингэснээрээ техникийн яндангаас хаягдах очноос үүдэлтэй гал түймрээс урьдчилан сэргийлэх;
- Төслийн талбайд хийгдэх зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн ажлыг мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөгөө, мэргэжилтний оролцоотойгоор төлөвлөн хэрэгжүүлэх;
- Зүлэгжүүлэлтийг 6 сарын эхээр явуулж, үрийг суулгахдаа нарийн ширхэгтэй тармуураар мөр гаргасны дараагаар 1-3 см-ийн гүнд суулган, мөрийн дагуу шороогоор жигд хучина.
- Амьтдыг дайжиж үргэхээс сэргийлэн хүчтэй дуу чимээ гаргахгүй байхыг анхааруулах;
- Төслийн талбайн орчмын нутаг дэвсгэрт ан амьтны амьдрах орчныг бусниулахгүй, үргэхгүй, алж устгахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

- Тухайн бүс нутагт дулааны улиралд амрагч, аялагчдын тоо эрс нэмэгдэж төслийн талбайн ойр орчимд майхантай хонох, өдрөөр зугаалах зэрэг үйл ажиллагаа өргөнөөр явагддаг учир амрах цэгт гал түлэх, түүдэг гал асаах тохиолдолд газрыг 50-70 см хүртэл гүн, 2.5-3.0 метр диаметртэй талбайг ухаж хайрга, чулуун дүүргэвч хийж зориулалтын байдлаар тохижуулж ашиглуулах;
- Ил задгайгаар халуун үнс, нурам, цог үлдээх зэргийг хатуу хориглох шаардлагатай гэж үзвэл торгох хүртэлх арга хэмжээг авч, хяналт тавих;
- Хог хаягдлын цэгийн талбайг сонгохдоо салхины зонхилох чиглэлийн доор байр сууц, хоолны газраас 60м-с багагүй зайд, бие засах газраас тусад нь нэг цэгт байрлуулах ба хатуу хог хаягдлын цэгийг ялаа, шавж үржихээс сэргийлэн тогмол ариутгаж байх;
- Баазын гэр, байшингуудын орчимд хог хаягдлыг ангилан ялгах сав байрлуулах;
- Ангилан ялгасан хаягдлыг (шил, лааз, хуванцар, гялгар уут, цаас г.м) хаягдлыг дахиварын үйлдвэр, дахивар нөөцийн цэгт тушаах;
- Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг орон нутгийн тохижилт үйлчилгээний компанитай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн хаягдлын цэгт богино хугацаанд зайлуулах;
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
- Ахуйн шингэн хаягдлыг MBR ахуйн бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан цэвэршүүлэх;
- Цэвэрлэгдсэн саарал усаар зүлэг ногоон байгууламж услах, бие засах газрын суултуурын усанд ашиглах зэргээр дахин ашиглах;
- Техникийн шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингэн галын аюулгүй нөхцөлд ариутгах, эсвэл дарж булах байдлаар цэвэрлэх, саармагжуулах;
- Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцох;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
- Хог хаягдлын тухай хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- Тусгай хамгаалалттай газар нутагт дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр орон сууц, үйлчилгээнд тавих шаардлага MNS 6426:2013 дугаар стандартыг барилга байгууламж, үйл ажиллагаа явуулахдаа мөрдлөгө болгох;
- Батлагдаагүй зураг төслөөр барилга объект барих, зөвшөөрөлгүйгээр байгалийн үндсэн болон дагалт баялаг ашиглах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр болон мэргэжлийн бус байдлаар байгалийн баялагаас дээж авах, тухайн бүс нутагт оршин амьдрагч бус амьтдыг нутагшуулах, жуулчдыг батлагдаагүй маршрутаар аялуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглох.;

Эдэлбэр газар шинээр барилга байгууламж барих, төслийн үйл ажиллагааг өргөтгөх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх;

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОХТ, ОХШХ)

“Планет интернэшнл” ХК-ийн “Тэрэлж лож” жуулчны бааз төслийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-05 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу уг төслийн БОННУ-ий тайланд үндэслэн боловсруулав.

БОННУ болон БОМТ нь 5 жилийн хугацаанд буюу 2022 оноос 2026 оныг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

Уг төслийн БОМТ нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой юм. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд БОННУ, БОМТ-ий хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанд (2022-2026 он) “Тэрэлж лож” жуулчны баазын үйл ажиллагааны үед шатуудад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд хийж гүйцэтгэх ажлууд, хяналт шинжилгээ хийх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа болон зардлын хамт тусгасан болно.

БОННУ-нд хамрагдаж буй уг төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнд 2022-2026 онд нийт **28800.0** мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарсан байна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар жилд 200.0 мян.төг зарцуулахаар байна. “Тэрэлж лож” жуулчны бааз төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 2022-2026 онд нийт 1000.0 мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарлаа.

Харин Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох, Түүх соёлын өвийг хамгаалах ажлууд хийгдэх шаардлагагүй гэж үзсэн тул төлөвлөгөөг нь боловсруулаагүй болно. Энэхүү урьдчилсан байдлаар төсөвлөсөн зардлын төсөвт төсөл хэрэгжүүлэгч жил бүр тодотгол хийж тус тайлангийн хүчинтэй байх хугацаанд жил бүрийн ТЖБОМТ-г боловсруулан БОАЖЯ-аар батлуулан хэрэгжүүлэх, төсөв зардлыг төслийн төлөвлөлтийн зардалд төвлөрүүлж байх шаардлагатай.

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал (2022-2026)

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Нийт зардал /мян.төг/ |
|--|--|------------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ | 16700.0 |
| 2 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 2850.0 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 2350.0 |
| 3 | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | - |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө | - |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | - |
| 6 | Удирдлага зохион байгуулалт, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2250.0 |
| 7 | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр | 1000.0 |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал (2022-2026 он) | | 25150.0 мян.төг |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Энэхүү бүлэгт өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенцуудын холбогдох шаардлагуудыг тодорхой тусгаж орууллаа.

Монгол Улсын эрх зүйн баримт бичгүүдийг давамгайлах чанараар нь авч үзвэл анхдагч эрх зүйн актуудад Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүд, Олон улсын гэрээнүүд, Улсын Их Хурлаас баталсан хуулиуд хамаарна. Хоёрдогч эрхзүйн актуудад УИХ-ын тогтоол, Дээд Шүүхийн тайлбар, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын яамдын тогтоол, Сайдын тушаал, Агентлагийн тушаал, Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ын тогтоол, Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ын тогтоол, Баг, хорооны иргэдийн нийтийн хурал (ИТХ)-ын тогтоол, Баг, хорооны Засаг даргын захирамжууд ордог байна.

Дээрх олон төрлийн эрх зүйн баримт бичгүүд нь Монгол Улсын байгалийн нөөц баялаг, байгаль орчинг ашиглах, хамгаалахад мөрдөгддөг. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ) нь байгаль орчинг хамгаалах, түүнд нөлөөлөх байдлыг үнэлэхтэй холбоотой хууль тогтоомжийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу ерөнхий чиг үүргийн яам юм. Аймаг болон Улаанбаатар хотын засаг захиргаа нь улсын болон орон нутгийн байгаль орчны хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан захиргааны ажлын алба, хэлтсүүдтэй. Ижил төрлийн функцийг сум, дүүргийн түвшинд орон нутгийн байгаль орчны байцаагчид гүйцэтгэдэг. Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг төрийн эрх мэдлийн хэмжээнд байгаль орчны байцаагчдыг томилох ажлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) хариуцан ажилладаг.

Жуулчны бааз байгуулах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийхэд дор дурдсан хууль эрх зүйн баримт бичгүүдийг баримтлан боловсруулсан бөгөөд эдгээр нь тус баазын цаашдын үйл ажиллагааг явуулахад цаг ямагт мөрдөн ажиллах тулгуур баримт бичгүүд болно. Байгаль орчныг хамгаалах талаар тавигдах шаардлагыг хуульчилсан хууль тогтоомжууд болон Засгийн газрын тогтоолууд, норм норматив, стандартуудыг судлан үзэж эдгээр эрх зүйн актуудаас уг төсөлд холбогдох, үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж байх заалтуудыг түүвэрлэн энэ бүлэгт орууллаа.

Хүснэгт 2. Монгол улсын хууль тогтоомж

| № | Хуулийн нэр | Батлагдсан, нэмэлт, шинэчлэн найруулга хийсэн он | Хуулийн ерөнхий утга |
|---|--------------------------------------|--|--|
| 1 | Байгаль орчныг хамгаалах тухай хууль | 1995 (2019 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 2 | Газрын тухай хууль | 2002 (2021 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино. |

| | | | |
|----|---|--------------------------------|--|
| 3 | Хөрсийг хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай | 2012 (2015 нэмэлт өөрчлөлт) | Хөрсний доройтол, нөхөн сэргээлт, цөлжилтөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулна. |
| 4 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай | 1994 (2019 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 5 | Усны тухай | 2012 (2021 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 7 | Амьтны тухай | 2012 (2017 нэмэлт өөрчлөлт) | Амьтныг хамгаалах, түүнийг өсгөн үржүүлэх, нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. |
| 8 | Байгалийн ургамлын тухай | 1995 (2015 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 9 | Ургамал хамгааллын тухай | 2007 (2021 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 10 | Агаарын тухай (шинэчилсэн найруулга) | 2012 (2019 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 11 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Тухай (шинэчилсэн найруулга) | 2012 (2017 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино. |
| 12 | Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) | 2017 (2017 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 13 | Соёлын өвийг хамгаалах тухай (шинэчилсэн) | 2001 (2021 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, |

| | | | |
|----|---|-----------------------------|--|
| | найруулга) | | сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 14 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай (шинэчилсэн найруулга) | 2012 (2017 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 15 | Агаарын бохирдлын төлбөрийн тухай | 2010 (2019 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 16 | Эрүүл ахуйн тухай | 2016 (2018 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 17 | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай | 1997 | Энэ хуулийн зорилт нь тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 18 | Ус бохирдуулсаны төлбөрийн тухай | 2012 (2019 нэмэлт өөрчлөлт) | Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |

Хүснэгт 3. Улсын их хурлын тогтоол

| № | Утга | Он, сар, өдөр | Дугаар |
|---|---|---------------|--------|
| 1 | Ногоон хөгжлийн бодлого | 2014-06-13 | 43 |
| 2 | Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр | 2011-02-6 | 2 |

Хүснэгт 4. Монгол улсын Засгийн газрын тогтоол

| № | Засгийн газрын тогтоол | Он, сар, өдөр | Дугаар |
|---|--|---------------|--------|
| 1 | Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр | 2014-09-19 | 298 |
| 2 | Аюултай хог хаягдлын жагсаалт батлах тухай | 2014-09-19 | 298 |
| 3 | Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр | 2011-09-21 | 277 |
| 4 | Ногоон хэрэм хөтөлбөр | 2005-03 | 44 |
| 5 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөр | 2020 | 24 |

**Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаатай холбоотой зарим тогтоол шийдвэр,
дүрэм журам, заавар, аргачлал**

| № | Дүрэм журмын нэр | Шийдвэр | Батлагдсан он | Дугаар |
|---|--|--|---------------|----------|
| 1 | “Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам” | Байгаль орчны сайдын тушаалын 1-р хавсралт | 2002 | 117 |
| 2 | “Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх журам” | Байгаль орчны сайдын тушаалын 2-р хавсралт | 2001 | 117 |
| 3 | “Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөх нэг удаагийн ажил үйлчилгээний хөлсний хэмжээ” | Байгаль орчны сайдын тушаалын 4-р хавсралт | 2001 | 117 |
| 4 | “Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам” | Байгаль орчны сайдын тушаал | 2006 | |
| 5 | “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал | 2019 | A/618 |
| 6 | Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам | Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал | 2014 | A-03 |
| 7 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам | Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал | 2014 | A-04 |
| 8 | Ус ашиглагч иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам | Байгаль орчин, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаал | 2018 | A/82/128 |
| 9 | Тусгай хамгаалалттай газарт мөрдөгдөх нэгдсэн өнгө төрх, загварчлал батлах тухай | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал | 2018 | A/498 |

Хүснэгт 6. Төслийн хүрээнд ашиглагдах стандартууд

| № | Стандартын дугаар | Стандартын нэр | Хамрах хүрээ |
|---|-------------------|--|---------------------------------------|
| 1 | MNS 6034:2009 | Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага | Төслийн бүх үйл ажиллагаанд |
| 2 | MNS 6426 - 2013 | Тусгай хамгаалалттай газар нутаг дах эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавин нийтлэг шаардлага | Төслийн бүх үйл ажиллагаанд |
| 3 | MNS 4958:2000 | Амралт сувилалын газрын үйлчилгээ | Төслийн бүх үйл ажиллагаанд |
| 4 | MNS 4946:2005 | Хоолны газрын ангилал зэрэглэл үндсэн шаардлага | Төслийн бүх үйл ажиллагаанд |
| 5 | MNS 5738: 2007 | Дэн буудал. Ерөнхий шаардлага | Төслийн бүх үйл ажиллагаанд |
| 6 | MNS 5824- 2007 | Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага | Төслийн бүх үйл ажиллагаанд |
| 7 | MNS 0900:2018 | Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 8 | MNS 4586:1998 | Усны хүрээлэн буй орчны чанар. Ерөнхий шаардлага | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |

| | | | |
|----|----------------------|---|--|
| 9 | MNS 2573:1978 | Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Усны чанарын үзүүлэлт | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 10 | MNS 0899:1992 | Усан хангамжийн эх үүсвэрийн сонголтонд тавигдах шаардлагууд, дүрэм журмууд ба эрүүл ахуйн шаардлагууд. | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 11 | MNS 4047:1988 | Байгаль орчны хамгаалалт. Усан мандал. Гадаргын усны чанарын хяналт шалгалтын журам. | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 12 | MNS 3342:1982 | Байгаль орчны хамгаалалт, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 13 | MNS 6148:2010 | Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 14 | MNS 5918:2008 | Байгаль орчин. Эвдрэлд орсон газрын ургамлын бүрхүүлийн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлагууд | Төслийн талбай дахь элэгдэл эвдрэлд өртсөн талбайд |
| 15 | MNS 3597:1983 | Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорх усыг эрдэс бодисын бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага | Төслийн явцад хэрэглэгдэх усан орчинд |
| 16 | MNS 4585:2016 | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага | Төсөл хэрэгжих орчны агаарын чанар. |
| 17 | MNS 3383:1982 | Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт | Төсөл хэрэгжих гадаад дотоод орчны агаарын чанар |
| 18 | MNS 4990:2000 | Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага | Төслийн үйл ажиллагааны үед |
| 19 | MNS 5885:2008 | Агаар бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх агууламж | Төсөл хэрэгжих гадаад дотоод орчны агаарын чанар |
| 20 | MNS 5914:2008 | Байгаль орчин. Газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт | Төслийн талбай дахь элэгдэл эвдрэлд өртсөн талбайд |
| 21 | MNS 5003:2000 | Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Дуу чимээний хэмжилтэнд тавих шаардлагууд | Төсөл хэрэгжих орчинд |
| 22 | MNS 12.1.009:1985 | Хөдөлмөр хамгаалалт. Шуугиан Орон сууц, иргэний барилгын шуугианы байж болох түвшин | Төсөл хэрэгжих орчинд |
| 23 | MNS 3297:1991 | Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ | Төслийн талбай дахь элэгдэл эвдрэлд өртсөн талбайд |
| 24 | MNS 3473:1983 | Байгаль хамгаалалт. Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт | Төсөл хэрэгжих үед |
| 25 | MNS 5002:2000 | Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Дуу чимээний стандартын ерөнхий шаардлагууд ба аюулгүй ажлын дүрэм журмууд | Төсөл хэрэгжих орчинд |
| 26 | MNS 4244:94 | Хөдөлмөр хамгаалалт стандартын систем, Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага | Үйлдвэрийн барилга байгууламж, объектуудад |

| | | | |
|----|-------------------|---|--|
| 27 | MNS 5080:2001 | Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ | Ажилчдын ажлын байрны орчин нөхцөл |
| 28 | MNS 4967:2000 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томъёо, тодорхойлолт | Ажлын байрны нөхцөл |
| 29 | MNS 5566:2005 | Гал гарах үед анхааруулгын самбар ,объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ногдох стандарт | Ажлын байрны нөхцөл |
| 30 | MNS 4288:1995 | Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологийн түвшинд тавих үндсэн шаардлага | Төсөл хэрэгжих орчинд |
| 31 | MNS 6561:2015 | Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага | Төсөл хэрэгжих орчинд |
| 32 | MNS 5850:2008. | Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Төсөл хэрэгжих орчинд |
| 33 | MNS 3985:1987 | Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл | Төсөл хэрэгжих орчинд |
| 34 | MNS 3474:2003 | Ургамал хамгаалал. Нэр томъёо, тодорхойлолт | Төсөл хэрэгжих орчинд |
| 35 | MNS 3475:2003 | Ургамлын хорио цээр. Нэр томъёо, тодорхойлолт | Төсөл хэрэгжих орчинд |
| 36 | UCS 2003A:2020 | Дуу чимээний бохирдол. Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж | Төсөл хэрэгжих орчинд |
| 37 | MNS 5344:2011 | Ахуйн хог хаягдлын тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага | Төслийн үйл ажиллагаанаас гарах хаягдал |
| 38 | MNS 4585:2007 | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага | Төсөл хэрэгжих орчны агаарын чанар |
| 39 | MNS 5342:2007 | Автозогсоол, Ангилал ба ерөнхий шаардлага | Төслийн талбай дахь хатуу хучилттай зам талбай эвдэрсэн тохиолдолд |
| 40 | MNS 6056:2009 | Явган хүний замыг төлөвлөх | |
| 41 | MNS 5013:2009 | Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга | Баазын тээврийн хэрэгслүүд |
| 42 | MNS 5014:2009 | Дизель хөдөлгүүртэй автомашин-утааны тортогжилтын ЗДХ ба хэмжих арга | |
| 43 | MNS 6260:2011 | Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах | Ургамалжуулах талбайн хүрээнд |
| 44 | MNS 4943:2011 | Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усанд тавих ерөнхий шаардлага. | Үйл ажиллагаанд |
| 45 | MNS 6148:2010 | Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Үйл ажиллагаанд |
| 46 | MNS 6063:2010 | Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ | Үйл ажиллагаанд |
| 47 | MNS 4934:2002 | Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага | Үйл ажиллагаанд |
| 48 | MNS 4597:2014 | Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага | Баазын тээврийн хэрэгслүүд |
| 49 | MNS 6043:2009 | Амралтын газар. жуулчны бааз. гэр буудалд тавих ерөнхий шаардлага | Үйл ажиллагаанд |
| 50 | MNS 5409:2004 | Чөлөөт цаг, Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо | Үйл ажиллагаанд |

| | | | |
|----|-----------------|--|-----------------------|
| 51 | MNS 5850:2008 | Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Үйл ажиллагаанд |
| 52 | MNS 5924:2015 | Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага | Үйл ажиллагаанд |
| 53 | MNS 0900:2018 | Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ | Үйл ажиллагаанд |
| 54 | MNS 4588:2008 | Хэрэглэгдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлага | Төсөл хэрэгжих орчинд |
| 55 | MNS 4943:2011 | Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага | Төсөл хэрэгжих орчинд |
| 56 | MNS 5161-2:2002 | Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт. Хоёрдугаар хэсэг. Үйлдвэрлэл | Төсөл хэрэгжих орчинд |

Хүснэгт 7. Төслийн хүрээнд баримталж ажиллах байгаль орчны зарим дүрэм, журмууд

| № | Байгаль орчны дүрэм, журмын нэр | Баталсан газрын нэр, огноо |
|----|---|--|
| 1 | Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам | Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаал |
| 2 | Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам | Байгаль орчны сайдын 2002 оны 117 дугаар тушаал |
| 3 | Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал |
| 4 | Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээ тогтоох журам батлах тухай | Байгаль орчны сайдын 2019 оны 316 дугаар тушаал |
| 5 | Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулахцэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам | БОАЖСайд, ЭМСайдын хамтарсан 2018.04.05-ны А/82/128 тооттушаал |
| 6 | Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам | БОАЖСайд, ЭМСайдын хамтарсан 2015.06.05-ны А/230/127 тооттушаал |
| 7 | Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам | БОАЖСайд, ЭМСайдын хамтарсан 2018.04.05-ны А/82/128 тооттушаал |
| 8 | Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байрлуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам | Засгийн газрын тогтоол № 116, 2018 оны 05 сарын 02 |
| 9 | Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм | Эрчим хүчний сайдын 2014 оны 08 сарын 22-ны өдрийн 101 дугаар тушаал |
| 10 | Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаал |

Байгаль орчны салбарын хуулийн хэрэгжилтийг хангахын тулд холбогдох тушаал шийдвэрийг Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох яамнаас баталж, мөрдөн хэрэгжүүлдэг, “Хөх чоно гурав” ХХК нь “Хос хэрэм” жуулчны баазын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газар, сайд нарын тушаалаар батлагдсан тогтоол шийдвэр, дүрэм журам, заавар, аргачлал бусад холбогдох дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Тэрэлж лож” жуулчны бааз төсөл
Төсөл хэрэгжүүлэгч: “Планет интернэшнл” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011022080
Аж, ахуйн нэгж байгууллагын регистрийн дугаар: 2769727
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельс, Чингисийн өргөн чөлөө 98,
 Лүүк монголиа барилга

2.2. Төслийн зорилго

Тэрэлж лож жуулчны бааз нь 2005 оноос хойш Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт зөвхөн дулааны улиралд үйл ажиллагаа явуулж ирсэн. Иймд тус жуулчны баазад нэмэлт хөрөнгө оруулалт хийж, жилийн 4 улирлын турш үйл ажиллагаа явуулах боломжтой амралтын цогцолбор байгуулах зорилтын хүрээнд “Тэрэлж лож” жуулчны бааз нь өөрийн 9.5 газрыг өргөтгөж өвөл ажилладаг зочид буудал барихаар төлөвлөж байна. Мөн гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авч байгалийн өвөрмөц тогтоц, унаган төрхийг алдагдуулахгүйгээр амраахын зэрэгцээгээр эх орноо сурталчлах болон ажлын байр нэмэгдүүлэхэд төслийн зорилго, ач холбогдол оршино.

2.3. Төслийн байршил


“Планет интернэшнл” ХХК-ийн аялал жуулчлалын зориулалттай газар нь нийслэл Улаанбаатар хотоос зүүн тийш Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Онгоцотын аманд байрладаг. Тус ам нь Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэгт Хэнтийн тайгын өмнөд хэсэг ойт хээр бүхий дундаж өндөр уулсыг эзлэн оршино. Тэрэлж лож жуулчны бааз нь Туулын гүүрнээс зүүн хойш 14.9 км зайд байрладаг.

Хүснэгт 8. Төслийн талбайн координат

| № | Одоо ашиглаж буй талбай | | Төлөвлөж буй талбай | |
|------------------|-------------------------|---------------------|-------------------------------|-------------------|
| | Өргөрөг, X | Уртраг, Y | Өргөрөг, X | Уртраг, Y |
| “А” хэсэг | | | Төлөвлөж буй “А” хэсэг | |
| 1 | 47° 53' 29.084" N | 107° 24' 44.251" E | 47° 53' 25.96" N | 107° 24' 58.64" E |
| 2 | 47° 53' 31.735" N | 107° 24' 46.047" E | 47° 53' 28.44" N | 107° 24' 49.77" E |
| 3 | 47° 53' 31.524" N | 107° 24' 49.776" E | 47° 53' 29.99" N | 107° 24' 39.17" E |
| 4 | 47° 53' 33.599" N | 107° 24' 51.705" E | 47° 53' 29.75" N | 107° 24' 38.36" E |
| 5 | 47° 53' 34.021" N | 107° 24' 50.592" E | 47° 53' 31.23" N | 107° 24' 28.87" E |
| 6 | 47° 53' 34.542" N | 107° 24' 51.025" E | 47° 53' 31.04" N | 107° 24' 44.34" E |
| 7 | 47° 53' 34.151" N | 107° 24' 52.260" E | 47° 53' 39.34" N | 107° 24' 51.2" E |
| 8 | 47° 53' 36.888" N | 107° 24' 54.851" E | 47° 53' 39.13" N | 107° 24' 55.24" E |
| 9 | 47° 53' 33.348" N | 107° 25' 03.703" E | 47° 53' 34.75" N | 107° 25' 5.98" E |
| 10 | 47° 53' 26.681" N | 107° 24' 58.120" E | | |
| 11 | 47° 53' 29.104" N | 107° 24' 49.319" E | | |
| “Б” хэсэг | | | Төлөвлөж буй “Б” хэсэг | |
| 1 | 47° 53' 24.357" N | 107° 25' 5.701" E | 47° 53' 26.52" N | 107° 25' 9.41" E |
| 2 | 47° 53' 27.588" N | 107° 25' 1.670" E | 47° 53' 27.43" N | 107° 25' 10.98" E |
| 3 | 47° 53' 32.222" N | 107° 25' 5.776" E | 47° 53' 27 " N | 107° 25' 13.2" E |
| 4 | 47° 53' 29.512" N | 107° 25' 9.479" E | 47° 53' 26.41" N | 107° 25' 14.6" E |
| 5 | 47° 53' 29.641" N | 107° 25' 11.412" E | 47° 53' 28.77" N | 107° 25' 15.29" E |
| 6 | 47° 53' 30.147" N | 107° 25' 12.707" E | 47° 53' 26.59" N | 107° 25' 19.85" E |
| 7 | 47° 53' 29.941" N | 107° 25' 12.995" E | 47° 53' 24.80" N | 107° 25' 18.32" E |
| 8 | 47° 53' 28.772" N | 107° 25' 15.291" E | | |
| 9 | 47° 53' 26.412" N | 107° 25' 14.602" E, | | |
| 10 | 47° 53' 26.999" N | 107° 25' 13.203" E | | |
| 11 | 47° 53' 27.435" N | 107° 25' 10.982" E | | |

Тэрэлж лож аялал жуулчлалын бааз нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг, улсын тусгай хамгаалалттай Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Онгоцотын аманд 2005 оноос эхлэн аялал жуулчлал, амралтын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус бааз нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулт их мужид багтах Хэнтийн дэд мужийн Горхи-Тэрэлжийн районд ойт хээрийн бүсэд багтах бөгөөд нийт 9.5 га эдэлбэр газартай ба Улаанбаатар хотоос 56 км-ийн зайтай Өвөр Горхийн голын хөндийн баруун талд Хэнтийн нурууны дундаж өндөртэй Дүнхэн, Номт уулын урд энгэрт байрладаг.

Төслийн байршлын тойм зургийг доор үзүүлэв.



Зураг 1. “Тэрэлж лож” жуулчны баазын байршлын тойм зураг




Зураг 2. “Тэрэлж лож” жуулчны баазын харагдах байдал

2.2. Төслийн төлөвлөлт, хүчин чадал

“Тэрэлж лож” жуулчны бааз нь 2005 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гадаад дотоодын аялагч, жуулчдыг хүлээн авч үйлчилдэг.

“Планет интернэшнл” ХХК-ийн “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын газар ашиглах зөвшөөрөлтэй талбай нь 2 хэсэг газраас бүрдэх ба нийт 9.5 га байна. Тэрэлж лож жуулчны баазын нийт эдэлбэр газар нь ойт хээрийн бүсэд 5-10⁰-ын хэвгийтэй энгэр хажуу уулын бэлд байрлах ба нийт эдэлбэр газрын хэмжээ нь 9.51 га буюу 95 100 м² талбайтай бөгөөд дотроо А, В гэсэн хоёр хэсэгт хувааж болно. А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.25 га буюу 62 500 м², В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га буюу 32 600 м² талбайг тус тус эзлэнэ.

Нийт эзэмшил талбайн 90.7 % нь ямар нэгэн газар ашиглалт явагдаагүй хөрс, ургамлын эвдрэлгүй, байгаль орчны сөрөг нөлөөлөл байхгүй.



Зураг 3. “Тэрэлж лож” жуулчны баазын газар ашиглалтын зураг

“Планет интернэшнл” ХХК-ийн “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын газар ашиглах зөвшөөрөлтэй талбай нь 2 хэсэг газраас бүрдэх ба нийт 9.5 га байна. Одоогийн байдлаар амрагчид байрлах байшин барилга 3.025.02 м², явган хүний зам 1.544.33 м², ногоон байгууламж 806.77 м², авто зогсоол 1.473.83 м², агуулах, саравч 290.6 м², бохирын цооног 44.78 м², өнгөт хавтангаар тохижуулсан талбай 75.06 м², тоглоомын талбай 2.492.66 м², биеийн тамирын талбай 718.91 м², хувцас хатаах талбай 252.08 м² талбайг тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Жуулчны баазын газар ашиглалт

| № | Газар ашиглалтын төрөл | Талбай /м ² / |
|---|-------------------------------------|--------------------------|
| 1 | Амрагчид байрлах байшин барилга | 3.025.02 |
| 2 | Явган хүний зам | 1.544.33 |
| 3 | Ногоон байгууламж | 806.77 |
| 4 | Авто зогсоол | 1.473.83 м ² |
| 5 | Агуулах, саравч | 290.6 м ² |
| 7 | Бохирын цооног | 44.78 м ² |
| 8 | Өнгөт хавтангаар тохижуулсан талбай | 75.06 м ² |
| 9 | Тоглоомын талбай | 2.492.66 |
| 10 | Биеийн тамирын талбай | 718.91 м ² |
| 11 | Хувцас хатаах талбай | 252.08 м ² |
| Жуулчлалын баазын одоогоор ашиглаж буй нийт талбай | | 10724.04 |

“Тэрэлж лож” жуулчны бааз нь өөрийн 9.5 газрыг өргөтгөж өвөл ажилладаг зочид буудал барихаар төлөвлөж байна.



Зураг 4. Өргөтгөхөөр төлөвлөж буй талбай

Тус жуулчны бааз нь энгийн болон люкс нийт 44 гэр, зуны 10 байшинтайгаар 216 хүн нэг ээлжиндээ хүлээж авах хүчин чадалтай.

Хүснэгт 10. Төслийн хүчин чадал

| № | Барилга, байгууламж | Тоо хэмжээ | Хүчин чадал | Нийт хүчин чадал | |
|----|---------------------|-----------------------|--------------------------------------|-------------------|----|
| 1 | Люкс гэр | 16 | 4 хүн | 64 хүн | |
| 2 | Цомцог гэр | 28 | 4 хүн | 112 хүн | |
| 3 | Зуны байшин | 10 | 4 хүн | 40 хүн | |
| 4 | Ресторан | 1 | 60-70 хүн | 60-70 хүн | |
| 5 | Гэр ресторан | 1 | 40 хүн | 40 хүн | |
| 6 | Гэр лоунж | 1 | 30 хүн | 30 хүн | |
| 7 | Бохирын цооног | 2 | 15 м ³ -65 м ³ | 80 м ³ | |
| 8 | Цэвэр усны нөөцлүүр | 3 | 10 тн, 2 тн, 1.5 тн | 13.5 тн | |
| 9 | Боловсон | Том хүний боловсон 00 | 8 | Эр 4, Эм 4 | 8 |
| 10 | нийтийн бие | Хүүхдийн боловсон 00 | 2 | Эр 1, Эм 1 | 2 |
| 11 | засах байр | Душ | 16 | Эр 8, Эм 8 | 16 |
| 12 | | Угаалтуур | 16 | Эр 8, Эм 8 | 16 |
| 13 | Гүний худаг | | 1 | 1.8 л/с | - |

Ариун цэврийн өрөө, угаалгын өрөө тусдаа байрлах люкс гэр 16, шалны халаалттай, орчин үеийн байдлаар баригдсан Цомцог гэр 28, зуны байшин 10, “Өв соёл” ресторан, гэр ресторан, гэр лоунж, гэр музей, сагсан бөмбөгийн гадаа талбай, элсний волейболын талбай, хөл бамбагийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, гадаа агаарлах террас 2-тойгоор үйл ажиллагаа явуулдаг.

Ресторан 60-70 хүн хүлээн авах чадал бүхий заалттай. Гэр ресторан 40, гэр лоунж 30 хүнийг хүлээн авах ба нийт 140 хүнийг хүлээн авах чадалтай.

Зураг 5. Люкс гэр



Зураг 6. Люкс гэрийн дотор талын харагдах байдал



Зураг 7. Люкс гэрийн 00, Дүш

Люкс гэр. Бааз нь нийт 16 люкс гэртэй. 2021 онд Байгаль орчинд ээлтэй шалны халаалтаар дулаанаа шийдсэн бөгөөд зочин хүсвэл нүүрсний агууламжгүй шахмал модон түлшээр галлаж халаах боломжтой. Люкс гэрүүд дотроо 00, душ бүхий ариун цэврийн өрөөтэй. Тус бүр 2 ортой (200x160 см, 200x130 см), хөргөгч, ус буцалгагч болон бусад төрлийн цахилгаан хэрэглэлтэй. Гэр бүрийн гадаа амарч тухлах талбайтай, сийрсэн ширээ сандалтай.




Зураг 8. Зуны байшин

ХОС
НАХИА



Зураг 9. Зуны байшингийн дотор тал

Зуны байшин. Канад загвараар барьсан 10ш модон байшингууд нь цаг агаарын ямар ч нөхцөлд хамгийн тохиромжтой тохилог бөгөөд тус бүр 200x160 см, 200x130см-тэй 2 ортой.



Зураг 10. Цомцог гэрийн харагдах байдал



Зураг 11. Цомцог гэрийн дотоод байдал

Цомцог гэр. Бааз нь нийт байгаль орчинд ээлтэй шалны халаалт бүхий **28** цомцог гэр шинээр барьж байгуулсан. Жуулчны баазын дагаж мөрдөх стандартын дагуу бүх гэрээ тохижуулсан бөгөөд тус бүр 130 см х 200 см хэмжээтэй 4 ортой, шалны халаалттай, гаднаа нарлах талбайтай тул зочдыг ая тухтай амарч унтах бүх нөхцлөөр бүрэн хангасан. Гэр нэг бүрт дуудлагын хонх байрлуулсан тул зочин хүссэн цагтаа хүссэн үйлчилгээгээ гэрээсээ үйлчлэгч дуудан авах боломжтой.



Зураг 12. Явган хүний замыг тохижуулсан байдал

Гэр, байшин, ресторандын хооронд цементээр зам тавьж зүлэг гэмтхээс сэргийлсэн. Мөн гэрэлтүүлэг, камержуулалт зэрэгийг бүрэн хийсэн.



Зураг 13. “Өв соёл” ресторан

Ресторан. Тэрэлж Лож баазын “Өв соёл” ресторан нэг удаадаа 60-70 зочин хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай бөгөөд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан сүүлийн үеийн тоног төхөөрөмж, иж бүрэн тоноглогдсон гал тогоотой. Хүнсэндээ экологийн цэвэр бүтээгдэхүүн хэрэглэх зорилтын үүднээс 15х6 м-ийн хэмжээтэй, 2 ширхэг хүлэмжтэй бөгөөд өргөст хэмх, улаан лооль, салат навч, брокколи, ногоон сонгино, буйцаа, яншуй, босоо байцаа зэрэг нарийн ногоо тариалж, өөрийн хэрэгцээг бүрэн хангадаг бөгөөд мастер тогоочоор ахлуулсан мэргэжлийн баг үйлчилдэг. 2020 онд ресторандаа байгаль орчинд ээлтэй цахилгаан халаагуур хийсэн.



Зураг 14. Монгол гэр ресторан, гэр лаунж

Монгол гэр ресторан, гэр лаунж. Ресторан тус бүр нэг дор 30-40 хүн хүлээж авах хүчин чадалтай бөгөөд монгол үндэсний төрөл бүрийн хоол, хорхог, шорлог болон ази, европ хоолоор үйлчилдэг ба менюгээр болон өөрөө өөртөө үйлчлэх гэсэн хэлбэртэй. Энэ нь тусгайлан зассан саравчин дор шорлог хийх үйл явцыг тайлбартайгаар зочдод

харуулан, гадаа задгай талбайд ардын урлагийн тоглолт үзэн байгалийн сайханд хооллох боломжтой. Гар рестораны дулааныг байгаль орчинд ээлтэй шалны халаагуураар шийдсэн болно.



Зураг 15. Ажилчдын амралтын байр





Зураг 16. Төслийн талбай дахь сагсан бөмбөг, хүүхдийн тоглоомын талбай

Спортын талбай. Бааз зочдыг идэвхитэй, үр бүтээлтэй, спортлог амрахад зориулж сагсан бөмбөг, элсний гар бөмбөг, хөл бөмбөгийн талбай байгуулсан. Мөн модон бөмбөгийн хэрэгсэл, нум сум зэрэг төрөл бүрийн спортын хэрэгсэлтэй. Бяцхан зочиддоо зориулж орчин үеийн шинэлэг тоглоомын талбайтай. Мөн усан аялал, загасчлах, ууланд авиралт зэргийг зохион байгуулдаг нь зочдын сэтгэлд бүрнээ нийцсэн үйлчилгээ юм.



Зураг 17. Музей гэр (үйл ажиллагаа явуулж эхлэх үедээ барьдаг)

Музей гэр. Монгол малчин айлын маягаар тохижуулсан музей гэрт зочдод нүүдэлчин малчин айлын амьдралын хэв маягийн талаар бүрэн ойлголт өгөхүйц эдлэл хэрэгслийг байрлуулсан бөгөөд баазад ирсэн зочин бүр үнэ төлбөргүйгээр энэ гэрт зочилж, төрөл бүрийн сүү, цагаан идээ, айраг таргаар дайлуулж, эртний эдлэлийг үзэж сонирхож болно. Хэрвээ зочин хүсвэл гэрт хоноглох боломжтой бөгөөд Монгол ахуй, түүх соёлын талаар лекц сонсох бүрэн боломжтой.



Зураг 18. Ногоон байгууламж, сүүдрэвч

Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж. Бааз нь 2 газарт ногоон байгууламж, 4 газар цэцгийн мандал бий болгож байгал орчинд ээлтэй хамт олон байж нийгмийн хариуцлагаа дээшлүүлэх зорилгоор 500 орчим мод, бут суулгасан, (Гацуур, шинэс, тэхийн шээг, хус, голтгор, монос) 2016 онд 100 гаруй чацарганы бут суулгасан нь 2020 оноос жимсээ өгч эхэлсэн. 2021 онд нэмэлтээр 50 гаруй мод суулгасан болно. Монгол ахуйн соёлыг харуулсан модон сийлбэр, зочдын амарч тухлахад зориулсан сүүдрэвч, хүүхдийн тоглоомын талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулсан байна. зэрэг моднууд

Мөн 2 террасанд байх голт бор, буйлс, чацаргана, мойл жимсний мод зэрэг бутлаг моднуудыг жил бүрийн хавар комданийн нийт ажилчид очиж өмнөх жилийн өнжсөн өвсийг цэвэрлэж, хадаж янзалж хэвшсэн.



Зураг 19. Нийтийн бие засах газар

Ариун цэврийн өрөө. Бааз нь боловсон нийтийн бие засах газар, угаалга, душтэй Нийтийн 10 ширхэг 00, 16 ширхэг душ, 15 ширхэг угаалтуур бүхий ариун цэврийн өрөөнд мөн хүүхдэд зориулсан намхан угаалтуур, суултуур байрлуулсан байна. 2020 онд байгаль орчинд ээлтэй цахилгаан халаагууртай болгосон.

2.3. Төслийн технологи, үндсэн үйл ажиллагаа

Уг төслийн үндсэн үйл ажиллагаа нь амрагч, аялагчдыг хүлээн авч, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан тав тухтай орчинд амраах, аяллын хөтөлбөрт хамруулах, үйлчилгээ үзүүлэх, амрагчдыг үдэх гэсэн үе шат дарааллаар явагдана.

1. Зочид хүлээн авах бэлтгэл ажил-Амрагчдын захиалгыг утсаар болон пэйж хуудсаар урьдчилж авах ба ирэхээс дор хаяж 5 цагийн өмнө амрагчдын буудаллах байрыг бэлэн болгосон байна.

Компанийн холбогдох ажилтан амрагчдын ирэх цагийн хуваарьт өөрчлөлт орсон эсэхийг шалгаж тогтмол мэдээлэл өгнө.

2. Амрагчдыг хүлээн авах, амраах - Амрагчдыг ирэхэд амралтын гадна хаалган дээр угтан авна. Амралт, аялал жуулчлалын цогцолборын холбогдох ажилтан амрагчдыг

байрлах байранд нь оруулж, амралтын үед зохион байгуулагдах арга хэмжээ, амралтын газрын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.

Амрагчид амралтын байранд орсны дараа өрөөн дэх эд зүйлсийн бүрэн бүтэн байдал болон амралтын газрын мэдээлэлтэй танилцана. Үүнд:

- Амралтын өрөөний цагаан хэрэглэл, өрөөний бүрэн бүтэн байдлыг хянах,
- Амралтын үйл ажиллагааны цагийн хуваарь болон хоолны цагийн хуваарь зэрэгтэй танилцах
- Амрах хугацаандаа хичээллэж болох спортын болон бусад төрлийн зүйлсийн талаарх мэдээллийг авах,

Амрагчдыг олон хоногоор амрах бол Тэрэлжийн бүс нутгийн ойр орчмын байгальтай танилцуулах явган аяллуудыг зохион байгуулна.

Амрагчдыг үдэх -Амрагчдыг ая тухтай амарсан эсэх талаар асууж, санал хүсэлтийн дэвтэр ажиллуулах ба цаашид анхаарах үйлчилгээний талаар амрагчдаас сэтгэгдлийг асууж тэмдэглэж авна. Энэ нь “Тэрэлж лож” жуулчны баазын цаашид оршин тогтнох үндэс суурь болж өгнө.

2.4. Түүхий эд, туслах материал

2.4.1. Ус хангамж, хэрэглээ

Тэрэлж Лож жуулчны бааз нь унд ахуй, үйлчилгээний зориулалтаар 2014 онд зохих зөвшөөрлийн хүрээнд Ус Оюу ХХК-иар өөрсдийн эзэмшил талбайдаа 45 мн гүнтэй гүний худаг гаргуулжээ. 2016 оны 8-сард гаргасан нийслэлийн БОНХГ-аар ус ашиглуулах дүгнэлтээр тус худгийн насос нь 10 м³/цаг хүчин чадалтай, 128 м напортай бөгөөд хоногт 155.52м³ ус ашиглах боломжтой. Зуны жуулчдын идэвхитэй үеэр хоногт дунджаар 36.34 м³ ус ашиглаж байна. Мөн 2020 оны 8-р сарын 02-ны өдрөөс 2022 оны 8-р сарын 02 хүртэлх ус ашиглах Дугаар 2021/10 тоот гэрээг Налайх дүүргийн ЗДТГ-тай хийсэн байна.

Харин худгийн шугам дээр 2014 оны 03 дугаар сард суурилуулсан LXSGR-32 загварын, 00226 дугаартай, 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 05875 м³ заалт бүхий усны тоолуурыг шинэ тоолуураар солисон байна. Стандарт, хэмжил зүйн газрын баталгаажуулсан LXSGR-32 загварын, 2004039814 дугаартай, 00000 м³ заалттай усны тоолуурыг 2020 оны 05 дугаар сарын 23-ны өдөр суурилуулсан.

“Тэрэлж лож” аялал жуулчлалын бааз нь жилд 5-р сарын 1-ээс 10-р сарын 1 хүртэл 150 хоног үйл ажиллагаа явуулдаг тул жилд дунджаар 32700 амрагчдыг, хоногт 216 хүн хүлээн авч үйлчилгээ үзүүлнэ гэж тооцлоо.

Амралтын газрын идэвхитэй үйл ажиллагааны үед амрагчдын унд ахуйн зориулалтаар хэрэглэх усны тооцоог БОНХАЖСайдын 2015.07.30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 14-р хавсралт дахь нормын (өрөөндөө онгоц, шүршүүртэй жуулчны бааз-200л/хоног/хүн) дагуу тооцсон болно.

Хүснэгт 11. Усны тооцоо

| № | Ус хэрэглэгч | Хэмжих нэгж | Норм, л | Хоногийн хэрэглээ, л | Жилийн хэрэглээ, м ³ /жил |
|-------------|--|--------------------|---------|----------------------|---|
| 1 | Ажилчид, | 30 хүн | 200 | 6000 л | 6 м ³ *150хон=900.0 м ³ |
| 2 | Жуулчид(өрөөндөө онгоц, шүршүүртэй люкс гэр) | 64 хүн | 200 | 12800 л | 12.8 м ³ *150 хон=1.920 м ³ |
| 3 | Жуулчид(гэр сууц бүий жуулчны бааз) | 152 хүн | 45 | 6840 л | 6.84 м ³ *150 хон=1.026 м ³ |
| 4 | Ресторан | 300 | 25 | 7500 л | 7.5 м ³ *150 хон=1.125 м ³ |
| 5 | Ногоон байгууламж | 800 м ² | 4 | 3200 л | 3.2 м ³ *10хон=32.0 м ³ |
| Нийт | | | | 36340 л | 5.003 м³ |

Дээрх тооцооноос харахад “Тэрэлж лож” жуулчны бааз нь 30 ажилчидтай мөн нэгэн зэрэг 216 хүн хүлээн авах чадалтай гэж үзэн нийт 246 хүнээр тооцлоо. Иймд унд-ахуйн зориулалтаар хоногт 36.34 м³, жилийн хэрэглээнд нийт 5.003 м³ ус ашиглахаар байна.

“Планет интернэшнл” ХХК-ийн гүний усны худаг нь 1.8 л/с ундаргатай тул хоногт 155.52 тонн ус гарах ба үүний 70%-ийг буюу 108.864 тонн ус хэрэглээнд ашиглах боломжтой. Гэвч дээрх тооцооноос үзэхэд жуулчны бааз нь өдөрт 36.34 тонн ус хэрэглэх учир гүний худгийн усны хэрэгцээ хангалттай хэмжээнд байна.

“Тэрэлж лож” жуулчны баазын ундны усны чанар, аюулгүй байдлыг үнэлэх зорилгоор 2021 оны 5-р сарын 24-ны өдөр тус баазын гүний худгаас дээж авч хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байна. Усны шинжилгээний дүнгээр тус худгийн ус нь шинжлэгдсэн үзүүлэлтийн түвшинд Монгол Улсын “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлагад нийцэж байна. Гүний худгийн усны шинжилгээний дүнг хүснэгт 2-2-т үзүүлэв.

Хүснэгт 12. Гүний худгийн усны шинжилгээний үзүүлэлтүүд

| № | Шинжилсэн үзүүлэлтүүдийн нэр, хэмжих нэгж | Шаардлага | Шинжилгээний дүн |
|----|---|---------------|------------------|
| 1 | ББЕТ | 100 | 9 |
| 2 | Salmonella spp | 0 | 0 |
| 3 | E. coli | 0 | 0 |
| 4 | Төмөр | <0.3 | 0.14 |
| 5 | Нитрат | <50.0 | 1.31 |
| 6 | Нитрит | <010 | 0.0078 |
| 7 | pH | 6.5-8.5 | 6.58 |
| 8 | Сульфат | <500.0 | 10.5 |
| 9 | Фосфат | <3.5 | 0.0 |
| 10 | Фтор | 0.7-1.5 | 0.27 |
| 11 | Хатуулаг | <7.0 мг-экв/л | 0.44 |
| 12 | Хлорид | <350.0 мг/л | 39.0 |
| 13 | Хуурай үлдэгдэл | <1000.0 мг/л | 568.0 |



Зураг 20. “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын гүний худаг

Төсөл хэрэгжүүлэгч “Планет интернэшнл” ХХК нь жуулчны бааз нь 10 тн, 2 тн, 1.5 тн-ын багтаамжтай эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай зориулалтын ган саванд усаа нөөцөлж хэрэглэж байна.

НАХИА



Зураг 21. Ажилчдын байрны ус нөөцлүүрийн сан

Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь гүний худгийг бохирдлоос хамгаалах зорилгоор Усны тухай хуулийн 22.3, БОНХАЖСайд болон БХБСайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дах заалтын дагуу ус хангамжийн эх үүсвэр/гүний худаг/-ээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс тогтоож мөрдөж ажиллах, жил бүр ус ашиглуулах дүгнэлтийг Нийслэлийн байгаль орчны газраар гаргуулж ус ашиглах гэрээ байгуулан, гэрээний дагуу усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлж байх шаардлагатай.

2.4.2. Цахилгаан эрчим хүчний хангамж

Цахилгаан эрчим хүчний хувьд УБЦТС ТӨХК-тай гэрээ байгуулсан бөгөөд 400 вольтийн хүчдэл бүхий цахилгааны байнгын эх үүсвэртэй ба төлбөрийг тухай бүр нь тушааж байна. Цахилгааны хязгаарлалтын үед дизель мотор ашигладаг.



Зураг 22. Жуулчны баазын КТПН

2.4.3. Дулаан хангамж

Дулааны хугацаанд үйл ажиллагаа явуулдаг учраас нэгдсэн дулааны систем байхгүй. Нийт 54 гэр, байшингаас 44 гэрийн шалны халаалттай, 10 байшин цахилгаан халаагуураар хална. 2021 онд 16 люкс гэрийг шалны халаалтаар шийдсэн ба зочин хүсвэл нэмэлтээр шахмал модон түлшээр галлаж халаах боломжтой болгосон. 2020 онд нэмэлтээр нийтийн ариун цэврийн өрөө болон ресторанаа цахилгаан бойлуурар халдаг пааран халаагуураар шийдсэн болно. Мөн ресторандаа нэмэлтээр таазнаас өлгөдөг ультра халаагуур байрлуулсан.

2.5. Хог хаягдал

“Тэрэлж лож” жуулчны бааз төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болон талбайн орчимд дуу чимээ, доргио чичиргээ, цацраг идэвхит бодисын эх үүсвэрүүд зэрэг физикбохирдол, хог хаягдлын эх үүсвэрүүд байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагаанаас ахуйн хатуу шингэн хог хаягдал гарна.

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын гол эх үүсвэрүүд, хаягдлын төрөл:

- ✎ Төслийн үндсэн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал буюу амрагчид болон ажиллагсдын ахуйн хэрэглээний хатуу хог хаягдал
- ✎ Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах утаа, тортог, бусад хийн болон шингэн хаягдал
- ✎ Хоолны үлдэгдэл, угаалга, ариун цэвэр, ахуйн бохир буюу шингэн хаягдал

Хатуу хаягдал

Уг амралтын газар нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед хоногт 80 хүн хүлээж авах ба нийт ажилчдын тоо нь 20 байх тул нэг хүний ахуйн хэрэглээнээс үүсэх хатуу хаягдлын хэмжээг дунджаар 1.5 кг, нийт хатуу хаягдал үүсгэх хүнийг тоог 100 байхаар тус тус тооцож ахуйн хэрэглээнээс үүсэх хатуу хог хаягдлын хэмжээг дараах томъёогоор тодорхойллоо.

$$X_{\text{ж}} = (X_{\text{x}} \times N_{\text{x}} \times A_{\text{ж}}) / 1000, \quad \text{тн/жил}$$

Энд: $X_{\text{ж}}$ - ахуйн хатуу хог хаягдал, тн/жил,

X_{x} - хоногт ажиллах хүн- 246 хүн

N_{x} - хоногт нэг хүнээс гарах хог хаягдлын норм, 1.5 кг

$A_{\text{ж}}$ - жилийн ажлын хоног, 150 хон

$$X_{\text{ж}} = \frac{(246 \times 1.5 \times 150)}{1000} 55.35 \text{ тн/жил (0.369 тн/хоног)}$$

Энэхүү тооцооноос үзэхэд хоногт дунджаар 0.369 тн буюу 369 кг орчим хатуу хог хаягдал гарахаар байна. Гэхдээ энэ нь үйл ажиллагааны үед буюу жил бүрийн 5-р сарын 1-ээс 9-р сарын 1-ны хугацаанд энэ хэмжээгээр гарна гэж үзэх нь зүйтэй. Харин бусад үед үйл ажиллагаа зогсох тул хатуу хог хаягдал гарахгүй.

Төсөл хэрэгжүүлэгч нь ахуйн хатуу хог хаягдлыг төслийн талбайд байрлах 2 тасалгаа бүхий бетонон шалтай төмөр торон хаалттай стандартын шаардлага хангасан хатуу хог хаягдлын цэгт ангилан ялгаж хуримтлуулан Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу ачуулан төслийн талбайгаас зайлуулдаг байна.



Зураг 23. Жуулчны баазын хатуу хаягдлын түр цэгийн өнөөгийн байдал

Хог хаягдлын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан журам, аргачлал, зааврын дагуу ангилан ялгаж тус тусад нь зориулалтын саванд хийж, төрөлжүүлэн галд тэсвэртэй, хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай, байгалийн хүчин зүйлийн нөлөөнд өртөж

хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байх шаардлага хангасан түр цэг байгуулсан байгаа нь хог хаягдал хийсч тархахаас бүрэн хамгаалж чадсан байна.



Зураг 24. Төслийн талбайд байрлуулсан хогийн сав

Ангилан ялгаж хуримтлуулсан хаягдлыг (цаас, шил, лааз, хуванцар, гялгар уут) дахин боловсруулах үйлдвэр, хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх ба дахин боловсруулах боломжгүй хаягдлыг хог хаягдлын гэрээний дагуу тогтмол хугацаанд зөвшөөрөгдсөн хаягдлын цэг рүү зайлуулж байх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь аялагчдын гэр байшингийн орчимд хуванцар сав хаях дараах загварын хогийн савыг байршуулж ажиллавал хатуу хог хаягдлыг ангилах ажлыг хөнгөвчлөх сайн талтай.



Зураг 25. Хуванцар сав хаях хогийн савны загвар

Хүснэгт 1. Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд

| № | Компанийн нэр | Үйл ажиллагааны чиглэл | Хаяг, холбоо барих утас |
|---|---|--|--|
| 1 | “Алтан оршихуй групп” ХХК | <ul style="list-style-type: none"> • Дугуй болон хаягдал резин • Ашиглагдсан тос | УБ, Баганхангай дүүрэг, 1-р хороо, химийн гудамж, Утас:70005065, 99104569 www.dakhivar.com |
| 2 | “Plastic center” ХХК | <ul style="list-style-type: none"> • Хаягдал зөөлөн гялгар уут | Утас: 88104308 |
| 3 | “Сан оргиу” ХХК | <ul style="list-style-type: none"> • Хаягдал гялгар уут • Хуванцар сав | ХУД Нарангийн энгэрийн хогийн цэг Утас: 96806849 |
| 4 | “ТЧМ” ХХК | <ul style="list-style-type: none"> • Хаягдал гялгар уут • Хуванцар сав | ХУД Улаанчулуутын хогийн цэг |
| 5 | “Нью Тушида” ХХК | <ul style="list-style-type: none"> • Дугуй болон хаягдал резин | УБ, Сүхбаатар дүүрэг, Утас: 99050019, 96660019 altansukh@newtushita.mn |
| 6 | “Иннахис” ХХК | <ul style="list-style-type: none"> • Хаягдал дугуй боловсруулах үйлдвэр | Утас: 99115097 |
| 7 | “Сайн цаас” ХХК | <ul style="list-style-type: none"> • Хаягдал картон цаас боловсруулах | БГД, 3-р хороо Дунд голын гудамж, Урайган ХХК-ийн байр 503 тоот, Утас 88108184 |
| 8 | “Түвшин сайхан” хоёрдогч түүхий эд авах төв | <ul style="list-style-type: none"> • Хаягдал машин • Зай хураагуур • Мотор хроп, төмөр, ган, ширэм • Төрөл бүрийн хуванцар сав | Утас:88130083, 96685858 |
| 9 | “Цэцүүх трейд” ХХК | Химийн бодисын сав, баглаа боодол | Төв аймаг, Сэргэлэн сум, Налайхын 4-р зөрлөг, МАК барилгын хажууд, Цэцүүх ПЕ&ПП дахин боловсруулах барилга, Утас: 99057786, 90097786 |

| | | | |
|----|---|--|--|
| 10 | "Хайби ойл" ХХК | Автын тос, тослох материалыг дахин боловсруулах | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон Утас: 70112205, 99098989 |
| 11 | "Элемент" ХХК | Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгалын төвлөрсөн байгууламж | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 26-р хороо, Нийслэл хүрээ өргөн чөлөө 404, Санрайс оффис центр 805 тоот Утас: 77113131, 86103790, 86113790 |
| 12 | Монголын хог хаягдлыг дахин боловсруулах холбоо | Хаягдал зай хураагуур авах, хог хаягдал дахин боловсруулах | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, City Tower, 12 давхарт, 1204 тоот Монголын хог хаягдлыг дахин боловсруулах холбоо |
| 13 | "Шинэ шил" ХХК | Шилний хаягдал авч боловсруулах үйлдвэр | 8000-6535, 9510-4373 |
| 14 | Царцаа ногоон | Дуудлагын дахивар тээвэр-Хаягдал цуглуулах үйлчилгээ | https://www.facebook.com/tsartsaanogoon/ |

Шингэн хаягдал

“Тэрэлж лож” жуулчны бааз төслийн үйл ажиллагааны үед ажилчид болон амрагчдын ахуйн хэрэглээнээс шингэн хаягдал гарна. Шингэн хаягдлын үүсэх хэмжээг нийт ус хэрэглээний 70%-иар тооцдог. Төслийн идэвхитэй үйл ажиллагааны үед хоногт 36.34 м³ ус хэрэглэх тул үүсэх шингэн хаягдал нь 25.43 м³/хоног байна.

Горхи-Тэрэлжийн БЦГ-ын Онгоцотын аманд үйл ажиллагаа явуулж буй “Тэрэлж лож” жуулчны бааз нь бохир усны 15-65 м³ багтаамж бүхий цооногтоо хуримтлуулан цооногийн 80%-д хүрэхэд зайлуулах шаардлагатай байдаг тул ойролцоогоор 16 хоног тутамд “МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК тай байгуулсан гэрээний дагуу соруулж зайлуулдаг байна.

“Тэрэлж лож” жуулчны баазын ундны усны эх үүсвэр/гүний худаг/-ийн энгийн хамгаалалтын бүсийн заагийг Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 2.6.2-д зааснаар Нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 500 метр хүртэлх зайд тогтоохоор тусгасан байна.

“Тэрэлж лож” жуулчны баазын гүний худаг нь ариун цэврийн байгууламж, бие засах газар, хог хаягдлын цэгээс 600-800 м зайд байрлаж байгаа нь энэхүү журмын шаардлагыг бүрэн хангаж байна.



Зураг 26. Бохирын цооног



Зураг 27. “Тэрэлж лож” жуулчны баазын ашиглаж буй соруулдаг нүхэн жорлон

ХОС
НАХИА

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

“Тэрэлж лож” жуулчны бааз нь зуны хугацаанд 4-5 сарын хугацаатайгаар ажилладаг. Төслийн талбай хүртэл Улаанбаатар-Тэрэлж чиглэлийн хатуу хучилттай авто замаар явж хүрэх учраас шороон зам ашиглахгүй тул агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь бага байна. Төслийн талбайд ойрхон агаар бохирдуулах эх үүсвэр байхгүй байна.

Иймд тухайн орчны байгалийн дурсгалт газар, жуулчны баазуудыг чиглэсэн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнөөр шороон замаас төслийн талбай болон түүний ойр орчимд агаарт тоосжилт үүсгэх, тээврийн хэрэгслийн дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн хаягдал тархах зэрэг сөрөг нөлөөллүүд үүснэ.

Харин төсөл хэрэгжүүлэгчийн амрагчдаа хүлээж авдаг гэр болон байшингууд нь шалны халаалттай тул агаар бохирдуулах эх үүсвэр болохгүй.

Энэхүү тайлангийн судалгааны ажлын хүрээнд “Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, хэмжилзүйн төв лаборатори”-д агаарын чанарын шинжилгээг хийлгэж дүнг дараах байдлаар нэгтгэлээ.



Зураг 28. Агаарын дээж авч буй байдал
Хүснэгт 13. Агаарын чанарын шинжилгээний дүн

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м ³ | Азотын давхар исэл мг/м ³ | Нийт тоос /TSP/ мг/м ³ | Дуу чимээ /ДБА/ |
|---|--|------------------|-----------------|--------------------------------|--------------------------------------|-----------------------------------|-----------------|
| 1 | Талбайн голоос | I/13 | 14:05 | 0.018 | 0.025 | 0.029 | 49 |
| 2 | Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт) | | | 0.450 | 0.200 | 0.500 | 60 |

Тус шинжилгээгээр судалгааны талбайн агаарт байх бохирдуулагч бодис нь агаарын чанарын стандарт MNS 4585:2016-с хэтрээгүй буюу бага байгаа нь тус газраас агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн шинжилгээг матрицаар нэгтгэж үзвэл:

Хүснэгт 14. Агаарын чанарын нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|---|---|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Эерэг нөлөөлөл | | | | | | |
| 1 | Ногоон байгууламж нэмэгдүүлснээр агаарт эерэг нөлөө үзүүлнэ. | | | LT | | |
| 2 | Шалны халаалт ашигладаг учир байгальд эерэг нөлөөлөл үзүүлнэ. | | | ST | | |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 3 | Тээврийн хэрэгслийн дутуу шаталтат хөдөлгүүрээс үүсэх бохирдол, амрагчдын хөл хөдөлгөөн зэргээс үүсэх агаар бохирдуулна | | ST | | | |
| 4 | Барилга байгууламж нэмж барих учир барилгын ажлаас үүсэх тоос тоосонцор үүснэ. | | | ST | | |
| Дүгнэлт | | Төслийн үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага зэрэг эрчимтэй шууд нөлөөлөл байх ба шалны халаалттай тул агаарын чанарт эерэг нөлөө үзүүлнэ. Харин Барилга байгууламж нэмж барих болон авто машин амрагчдын хөл хөдөлгөөн зэргээс богино хугацааны дунд зэргийн сөрөг нөлөө үзүүлэхээр байна. | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | шууд нөлөөлөл |
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

3.2. Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл

Горхи-Тэрэлжийн БЦГ-т амралт сувилал, жуулчны бааз олноор байгуулагдаж байгаа нь бүс нутгийн газрын гадаргын байгалийн өнгө төрх хүний үйл ажиллагаагаар өөрчлөгдөх нөхцлийг бүрдүүлж байна.

“Планет интернэшнл” ХХК-ийн “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазын газар ашиглах зөвшөөрөлтэй талбай нь 2 хэсэг газраас бүрдэх ба нийт 9.5 га байна. Одоогийн байдлаар амрагчид байрлах байшин барилга 3.025.02 м², явган хүний зам 1.544.33 м², ногоон байгууламж 806.77 м², авто зогсоол 1.473.83 м², агуулах, саравч 290.6 м², бохирын цооног 44.78 м², өнгөт хавтангаар тохижуулсан талбай 75.06 м², тоглоомын талбай 2.492.66 м², биеийн тамирын талбай 718.91 м², хувцас хатаах талбай 252.08 м² талбайг тус тус эзэлж байна.

Тэрэлж Лож жуулчны баазын нийт эдэлбэр газар нь 9.51 га буюу 95 100 м² талбайтай бөгөөд дотроо А, В гэсэн хоёр хэсэгт хувааж болно. А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.25 га буюу 62 500 м², В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га буюу 32 600 м² талбайг тус тус эзлэнэ.

А хэсгийн эдэлбэр газрын хэмжээ 6.25 га буюу 62 500 м² талбайн 5.49 га буюу 54930.6 м² талбайн хөрс, ургамал ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй. Үлдсэн 7569.4 м² буюу 0.76 га талбайд аялал жуулчлалын амралт, баазын үйл ажиллагааны чиглэлээр ашиглагдаж байна. В хэсгийн эдэлбэр газрын 3.26 га буюу 32 600 м² талбайн 3.14 га буюу 31423.1 м² талбайн хөрс, ургамал ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй бөгөөд энэ талбайд жуулчидад зориулсан “Эрийн гурван наадам” зохион байгуулдаг. Үлдсэн 1176.9 м² буюу 0.12 га талбайд аялал жуулчлалын амралт, баазын үйл ажиллагааны чиглэлээр ашиглагдаж байна.

Нийт эзэмшил талбайн 90.7 % нь ямар нэгэн газар ашиглалт явагдаагүй хөрс, ургамлын эвдрэлгүй, байгаль орчны сөрөг нөлөөлөл байхгүй. Тус баазын газар ашиглалтын зургаас харахад баазын газрын нөөц арвинтай мөн газар ашиглалтын тохиромжтой хэлбэрүүдийг сонгон ашиглаж, хөрс, ургамлын доройтол, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нь харагдаж байна.

Мөн төслийн үйл ажиллагаанд зориулан төслийн талбайг хашаалж хамгаалсан, үерийн аюулаас сэргийлсэн шуудуу татсан байна.

Энэхүү БОННУ-ний хүчин төгөлдөр байх хугацаанд төслийн талбайд шинээр газар ашиглалт явагдах тул эзэмшил талбай дахь газрын гадарга нь элэгдэж хөрс, ургамлан нөмрөг нь халцгайрна. Мөн авто зогсоол болон машин замыг хатуу хучилттай болгох, газрын гадарга элэгдэж доройтсон үед нь олон наст тарьж ургамалжуулах шаардлагатай.

Хүснэгт 15. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|---|---|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Эерэг нөлөөлөл | | | | | | |
| 1 | Явган хүний зам, гэрийн буурийг хатуу хучилттай болгосон | | LT | | | |
| 2 | Эдэлбэр газар нь газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлт хийх газарт үл хамаарна | | | | LT | |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 3 | Барилга байгууламж нэмж барих учир барилгын ажлаас газрын гадарга, хэвлийд сөрөг нөлөөлөл үзүүлнэ | | | ST | | |
| | Дүгнэлт | Төслийн үйл ажиллагаанаас газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөлөл богино хугацаанд дунд зэрэг нөлөөлөл байх ба шинээр барилга байгууламж барих, өргөтгөсний дараагаар эвдэрсэн газрын гадаргыг нөхөн сэргээж ургамалжуулах зэрэг арга хэмжээ авснаар газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах боломжтой. Мөн газрын ашиглалтын зориулалтыг өөрчлөхгүй байх хэрэгтэй. | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

шууд нөлөөлөл

| | |
|--|--------------------|
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

2.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

“Тэрэлж лож” жуулчны бааз байрлаж буй Горхи-Тэрэлжийн нутаг дэвсгэр нь Туул голын сав газарт хамаарах ба төслийн талбайн орчимд Горхийн уулсын энгэр бэл, сайр жалгаас эх авч хур бороо, үерийн усаар тэжээгддэг түр зуурын урсацтай жижиг голууд урсдаг. Эдгээр голууд нь хаврын шар ус, зуны хур борооны усаар тэжээгдэн түвшин нь нэмэгддэг бол хур бороо багатай, гандуу үед урсацгүй болдог байна. Уг төслийн үйл ажиллагаанаас гадаргын усны чанар болон нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

Төслийн талбайн гидрогеологийн нөхцөлийг авч үзэхэд газрын доорх урсацын түвшин жилд 50-100 мм буюу газрын доорх усны түвшин харьцангуй өндөртэй бүсэд хамаарч байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь баазрын үйл ажиллагааны үед хэрэглэх унд-ахуйн усыг төслийн талбай дахь өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. “Тэрэлж лож” жуулчны баазын идэвхитэй үйл ажиллагааны үед хоногт дунджаар 36.34 м³ ус хэрэглэх бөгөөд уг гүний худгаас хоногт 155.52 м³ ус авч ашиглах боломжтой тул ус хэрэглээ нь газрын доорх усны нөөцөд бага сөрөг нөлөө үзүүлнэ.

Хүснэгт 16. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|---|---|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Эерэг нөлөөлөл | | | | | | |
| 1 | Гүний худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, тоолууржуулсан | | | | LT | |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 2 | Төслийн үйл ажиллагааны үед унд-ахуйн зориулалтаар хоногт 36.34 м ³ гүний ус хэрэглэнэ. Саарал ус ашиглахгүй байна | | | LT | | |
| | Дүгнэлт | Төслийн үйл ажиллагааны үеийн усны хэрэглээг гүний худгийн ус дангаараа хангана. Мөн саарал усаа ашиглахгүй байгаа нь төслийн үйл ажиллагаанаас дунд зэргийн сөрөг нөлөөтэй | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | шууд нөлөөлөл |
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

2.4. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл

БОННУ-ний хээрийн судалгаанаас үзэхэд төслийн талбайгаас авсан дээжинд хөрсний урвалын орчин нь саармаг ба сул шүлтлэг, карбонатгүй, ялзмагийн агууламж дунд болон их (PI#01), цахилгаан дамжуулах чанараар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж бага (PI#01, 02) болон дунд зэрэг (PI#03, 04), хөдөлгөөнт калийн хангамж дунд зэрэг, нитратын азотын хангамж бага байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж хэмжээнд байна.

Төслийн эзэмшил талбай болон түүний ойр орчмын хөрсний гадарга ахуйн хатуу хог хаягдлаар бохирдоогүй, соруулдаг жорлонтой, хогийн сав битүүмжлэл сайтай, явган хүний зам, гэрийн буурь, тоглоомын талбай зэргийг хатуу хучилттай болгосон зэрэг нь хөрсний бохирдлоос хамгаалах чухал арга хэмжээ болсон байна.

Мөн дулааны улирал эхэлж аялагчид ихсэх үед тухайн орчимд ил задгай хог хаяж хуримтлагдаж болзошгүй тул төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайн орчны ахуйн хог хаягдлыг байнга цуглуулан цэвэрлэж байх хэрэгтэй.

Амрагчдын байшингийн бохир ус шугам хоолойгоор дамжин бохирын цооногт хуримтлагдаж, эндээс бохирын машинаар тээвэрлэн зайлуулдаг тул хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй байна.

Хүснэгт 17. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|---|--|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 1 | БОННУ-ний тайлангийн хүчинтэй байх 5 жилийн хугацаанд шинээр барилга байгууламж барьж өргөтгөл хийнэ | | | MT | | |
| 2 | Амрагчдын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас хөрсөнд тос масло асгарч гоожих, улмаар хөрсийг хүнд металаар бохирдуулах | | ST | | | |
| Дүгнэлт | | Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл бага болон дунд зэрэг эрчимтэй болзошгүй нөлөөлөл байна. Шинээр барилга байгууламж барих, өргөтгөл хийх нь хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөө үзүүлнэ. | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | шууд нөлөөлөл |
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Ургамлын хяналт шинжилгээний хүрээнд баазын эдэлбэр газарт судалгаа явуулахад баазын нийт эзэмшил талбайн 90.7 %-д нь уулын нугархаг хээрийн ботууль-

алаг өвст-улалжит бүлгэмдэл бүхий ургамал нөмрөгтэй бөгөөд тус баазын эдэлбэр газарт ховор болон нэн ховор ургамал тэмдэглэгдээгүй ба баазын баруун талаар багахан хэмжээний шинэсэн ойн захтай хиллэж байна.

“Тэрэлж лож” жуулчны баазын эзэмшил талбайд явуулсан хээрийн судалгаанаас үзэхэд Ширэг улалж (*Carex driuscula*), ленийн бортууль зэрэг ургамал 10-25%-ийн бүрхэцтэй *Cop1* арвитайгаар, хиаглаг түнхэ (*Elymus chinensis*), Замын таван салаа (*Plantago depressa*), Эмийн сөд өвс (*Sanguisorba officinalis*), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Хөдөөгийн шаралзгана (*Sonchus arvensis*), Арзгар согсоолж (*Heteropappus hispidus*), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*), Бүхэлнавчит багдай (*Dontostemon integrifolius*), Эмийн багваахай (*Taraxacum officinalis*) зэрэг Ботууль-алаг өвс-улалжит/**У-II-2-2/** бэлчээрийн ургамлууд зонхилон тархсан байна.

“Тэрэл лож” жуулчны баазын талбайд аялал жуулчлалын зориулалтаар байшин, гэр, хүүхдийн тоглоом, автомашины зогсоол, сагс, волейболын талбай цементлэж, явган хүний зам тавьсан байгаа нь ургамлан нөмрөг нэмж талхагдалд өртөхөөргүй төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага байна.

Хүснэгт 18. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|--|---|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Эерэг нөлөөлөл | | | | | | |
| 1 | Явган хүний зам талбайг хатуу хучилттай болгосон. | | | LT | | |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 2 | БОННУ-ний тайлангийн хүчинтэй байх жилийн хугацаанд шинээр барилга байгууламж барих, өргөтгөл хийх тул ургамлан нөмрөгийг доройтуулах үйл ажиллагаа явагдана | | | MT | | |
| 3 | Амрагчдын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас хөрсөнд тос масло асгарч гоожих, улмаар ургамлын ургалтыг доройтуулах, зогсоох | | LT | | | |
| Дүгнэлт | | Баазын доторх явган хүний зам талбайг хатуу хучилттай болгосон нь урт хугацаанд ургамлан нөмрөгт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин шинээр барилга байгууламж барих нь дунд хугацаанд шууд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн амрагчдын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал алдагдаж хөрсөнд тос масло асгарч гоожих зэрэг нь болзошгүй бага зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | шууд нөлөөлөл |
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

2.6. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Горхи-Тэрэлжийн БЦГ-ын дурсгалт газар, жуулчны баазуудыг чиглэсэн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөний улмаас ан амьтад үргэж дайжих, байршлаа солих, тархац нутаг нь хумигдах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй юм.

Хүснэгт 19. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|--|--|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 1 | Цогцолборыг зорих тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чимээ болон бусад дуу чимээ үүсгэн ан амьтад үргэж тархац нутаг нь хумигдаж болзошгүй. | | LT | | | |
| | Дүгнэлт | Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага зэрэг бөгөөд урт хугацаанд үргэлжилнэ. Төслийн үйл ажиллагааны үед дуу чимээ үүсгэн амьтны аймагт тайван бус нөлөөлөл үүсгэнэ. | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | шууд нөлөөлөл |
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

2.7. Төслөөс үзүүлэх бусад нөлөөлөл

“Тэрэлж лож” жуулчны баазын үйл ажиллагааны үед тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалд сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд ажилчдын анхаарал болгоомжгүй байдлаас үүдэлтэй осол аваари гарч болзошгүй. Харин энэхүү төсөл хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Хүснэгт 20. Төслөөс үзүүлэх бусад нөлөөллийн шинжилгээний матриц

| № | НӨЛӨӨЛӨЛ | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|----------------|--|---|------|------|----|---------|
| | | Нөлөөгүй | Бага | Дунд | Их | Аюултай |
| Эерэг нөлөөлөл | | | | | | |
| 1 | Орон нутгийн орлого нэмэгдэх, улирлын чанартай ажлын байр нэмэгдэх, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | | | LT | | |
| 2 | Жуулчин, аялагчдын алжаалыг тайлах, байгалийн үзэсгэлэнт газраар аялах таатай боломжийг бүрдүүлэх | | | LT | | |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| 3 | Болзошгүй аюул осол гарах | | | ST | | |
| | Дүгнэлт | Нийгэм, эдийн засагт урт хугацаанд дунд зэргийн эерэг нөлөө үзүүлэх бөгөөд болзошгүй аюул осол буюу байгалийн гамшигт үзэгдэл гарсан тохиолдолд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)


MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | шууд нөлөөлөл |
| | болзошгүй нөлөөлөл |
| | хам нөлөөлөл |

2.8. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Төслийг хэрэгжих явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн түвшинг тогтоох зорилгоор эерэг болон сөрөг нөлөөллүүдийг жагсааж нөлөөллийн үргэлжлэх хугацаа, үйлчлэх хүрээг шинжилж хувийн жинг тодорхойлох замаар шинжилгээ хийв. Нийт нөлөөллийн 75% нь шууд, 25% нь шууд бус буюу болзошгүй сөрөг нөлөөлөлд хамаарна. Нөлөөллийн 55.6% нь урт хугацааны, 11.1% нь дунд хугацааны, 33.3% нь богино хугацааны нөлөөлөлд хамаарна. Нөлөөллийн 42.9% нь эерэг, 57.1% нь сөрөг нөлөөлөл байна.



Зураг 29. Нөлөөллийн үргэлжлэх хугацаа ба хэлбэр

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх бүх төрлийн нөлөөллүүдийг нэгтгэн хувийн жинг тодорхойлов. Нөлөөллийн шинжилгээнээс үзэхэд нийт нөлөөллийн 37% нь эерэг нөлөөлөл, 25% бага зэргийн хүчтэй сөрөг нөлөөлөл, 38% дунд зэргийн хүчтэй сөрөг нөлөөлөл байна.



Зураг 30. Төслийн үйл ажиллагааны явцад илрэх эерэг ба сөрөг нөлөөллийн эзлэх хувь

Төслийн нөлөөлөл ерөнхийдөө дунд зэргийн хүчтэй нөлөөлөлд хамаарна. Үйл ажиллагааны явцад аюултай сөрөг нөлөөлөл ажиглагдахгүй бөгөөд орчны бүрэлдэхүүн хэсгүүдээс газрын доорх ус, агаар мандал, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймагт сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Эдгээрээс хөрсөн бүрхэвч, газрын доорх ус, ургамлан нөмрөгт дунд эрчмээр, агаар мандал, газрын гадарга, амьтны аймагт бага эрчмээр олон төрлийн сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Төсөл хэрэгжүүлэх явцад нөлөөллийн шинжилгээний дүнг үндэслэн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний зөвлөмжүүдийг дараах 4-р бүлэгт тусгасан болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

“Тэрэлж лож” жуулчны баазын үйл ажиллагааны үед орчны агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, бууруулахын тулд доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Ногоон байгууламжийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх
- БОННУ-ний БОМТ (ОХШХ) –нд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад бохирдуулагч бодисын хэмжилтийг тогтмол хугацаанд хийж, төслийн талбайн орчны агаарын бохирдолтыг хянах, агаар бохирдуулагч бодисуудыг ЗДХ-ээс хэтрүүлэхгүй байх;
- Төслийн үйл ажиллагаанд ашиглах бүх авто тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөрийг тогтмол төлөх, агаарт хорт хийн хаягдал ялгаруулж байгаа тохиолдолд хөдөлгүүрт шүүлтүүр тавих, солих арга хэмжээ авах;
- Хог хаягдлыг шатаах аргаар устгахгүй байх;

4.2. Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанаас хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Эдэлбэр газар дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон хүний үйл ажиллагаагаар элэгдэж халгайрсан, доройтсон талбайд нөхөн тарилт хийх буюу олон наст ургамал тариалах, нөхөн сэргээх;
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тухайн орчимд зам дагуу хаягдсан хатуу хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг тогтмол авах;
- Машин тоног төхөөрөмж засварлахдаа түлш болон бензин шатахуун, тэдгээрийн хаягдал савыг байгаль дээр ил хаяхгүй байх;
- Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг Газрын тухай хуулийн дагуу 5 жил тутамд 1 удаа хийлгэж байх;
- Төв замаас эдэлбэр газар хүртэл нэг замаар явах, замын дагуу 500-1000 м-ийн зайд хаяг, замын тэмдгийг байршуулах, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоолыг байр, сууцнаас 200 м-ээс багагүй зайд байрлуулж тэмдэгжүүлэх, онцын шаардлагагүй үед тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх;
- Баазын орчимд олон салаа зам гаргаж хөрсийг талхлахгүй байх үүднээс үйлчилгээний цэгүүд, аяллын маршрутын зам зэргийг оновчтой төлөвлөн, засч янзлан тохижуулж, шаардлагатай гэж үзвэл бусад зам үүсэх магадлалт хэсгүүдийг хааж ургамлын үр цацаж ургамалжуулах;
- Гал түймрийн аюулаас ямагт сэрэмжилж, урьдчилсан арга хэмжээ төлөвлөх, галын буланг хүний нүдэнд ил харагдахуйц байрлалд байгуулж, галын хор, элсний нөөцийг нэмэгдүүлэх, хүрз, сүх, эсгий зэрэг шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр тоноглох;

- Эргэн тойрны 0.5-1.0 км радиустай газрыг хяналтандаа авч бохирдохоос сэргийлж, тогтмол цэвэрлэж байх, хяналт тавих, шаардлагатай үед амрагчдад шаардлага тавьж болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх;

4.3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдал гарахгүй, унд ахуйн зорриулалтаар ус хэрэглэх тул усны нөөц болон чанарт бага сөрөг нөлөөлтэй.

Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах зорилгоор доорхи зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

- Гүний худгийг БОНХСайдын 2013.05.16-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу заавал тоолууржуулах, тоолуурыг баталгаажуулж, тоолуурын заалтын дагуу усны төлбөр тооцоог төлөх;
- Хоногт 50 м³-аас бага ус хэрэглэх тул Нийслэлийн байгаль орчны газраар жил бүр ус ашиглах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулан ажиллах;
- Гүний худгийг бохирдлоос хамгаалах зорилгоор Усны тухай хуулийн 22.3, БОНХАЖСайд болон БХБСайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дах заалтын дагуу ус хангамжийн эх үүсвэр/гүний худаг/-ээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс тогтоож мөрдөж ажиллах;
- Ахуйн бохир усыг биоректорын аргаар цэвэршүүлдэг Герман улсын “MBR” төхөөрөмжийг суурилуулан цэвэршүүлэх, уг төхөөрөмжөөр цэвэршүүлсэн саарал усыг төслийн талбайн орчны зүлэг ногоон байгууламж, зам талбайг услахад ашиглах;
- Горхи-Тэрэлжийн БЦГ-ын байгалийн онцлог нь хур тунадасны утга өндөртэй тул хаврын үед шар усны үер, хур борооны улиралд үер усны аюулаас сэргийлэх далан бусад барилга байгууламжийг заавал байгуулах нэн шаардлагатай.
- Үер усны болон галын түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч, схем боловсруулан баталж, шаардлагатай техник хэрэгслийг бэлтгэн, ажилтан амрагчдад осол аваарын үед авах арга хэмжээний талаарх сургалт, семинарыг тодорхой давтамжтайгаар заавар явуулах;

Усны нөөцийн хомсдолоос сэргийлэх зорилгоор усыг хэмнэлттэй ашиглах дараах технологиудыг санал болгож байна. Үүнд:

САНТЕХНИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН СОНГОЛТ



Ариун цэврийн өрөөнд сантехникийн эко төхөөрөмжүүд суурилуулж ашиглах нь усыг хэмнэх шилдэг арга юм. Тухайлбал бүх бочкинд усны зарцуулалтыг их болон бага хувилбараар сонгох хос даралтат товчлуурууд, цоргоны хошуунд цацруулалтыг нэмэгдүүлэх зэрэг нэмэлт шийдлийг энд дурдаж болно. Сантехникийн төхөөрөмжүүдээс суултуур нь хамгийн их

ус хэрэглэдэг, иймээс усыг хэмнэх зорилгоор хос даралттай товчлууртай суултуурыг заавал ашиглах шаардлагатай.



Мөн цоргоор гарах усны урсгалд агаар нэмж өгөх, усны урсгалын хэлбэрийг өөрчлөх аргууд нь их хэмжээний ус хэрэглэж байгаа мэдрэмжийг хүнд төрүүлдэг бөгөөд ингэснээр усыг 60% хүртэл хэмнэдэг.

СААРАЛ УС АШИГЛАХ

2010 онд УИХ “Их Хурлын тухай” хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн 24 дүгээр тогтоол гаргаж, “Ус” үндэсний хөтөлбөрийг баталсан байдаг. Уг хөтөлбөрт ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй айл өрх, албан газар болон жуулчны баазуудад байгаль орчинд халгүй жорлон (био болон хуурай жорлон), хаягдал (саарал) усыг цэвэршүүлэн хэрэглэхэд хялбар дэвшилтэт технологийг нэвтрүүлж, тэдний өдөр тутмын хэрэглээнээс үүсэх хаягдал бохир усны хэмжээг багасгана” гэж тусгасан билээ.

Нийслэлийн Засаг даргын 2012 оны хоёрдугаар сарын 14-ны өдрийн 85 дугаар захирамж гарч, шинээр баригдах орон сууцны хорооллуудын барилга байгууламжуудын ажлын зураг төсөлд хөрсний ус болон саарал усыг ашиглаж байхаар тусгуулан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд бохир ус цэвэрлэх байгууламж нь саарал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжтэй байх ёстойг хуульчлан заасан байдаг.

Иймд Монгол улсын стандарт “Саарал усны систем. Ерөнхий шаардлага MNS BS 8525-1:2015” –ийг мөрдөж ажиллах, угаалтуур, ваннаас гарсан усыг тусад нь хуримтлуулж бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэж ариутгал хийгээд буцаагаад ариун цэврийн өрөөний суултуурт ашиглах замаар саарал усыг хэрэглэх, мөн зам, талбай, зүлэг услах, автомашин угаах зэрэгт ашиглаж болох юм.

Бид ХБНГУ-ын “Busse MF” фирмийн “MBR” хэмээх ахуйн бохир усыг мембран биореكتورын аргаар цэвэрлэдэг төхөөрөмжийг санал болгож байна. Уг төхөөрөмж нь угсарч суурилуулахад газар шорооны ажил шаардлагагүй, цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах боломжтой, 5-200 хүний хүчин чадалтай, бохир усыг 99.97% цэвэршүүлдэг, ундны усны зарцуулалтыг хэмнэдэг зэрэг олон талын ач холбогдолтой төхөөрөмж юм. Иймээс төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү БОННУ-ний хүчинтэй байх хугацаанд уг төхөөрөмжийг суурилуулах талаар мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллан суурилуулах шаардлагатай.

4.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх хүчин зүйл бага бөгөөд хатуу хучилттай замаас бусад хэсгээр тээврийн хэрэгсэл зорчихыг хатуу хориглох хэрэгтэй. Мөн шинээр барилга байгууламж барих тул үүнээс үүдэж эдэлбэр газрын хүрээнд ургамлан нөмрөг нь талхлагдаж доройтсон хэсэгт бэлчээрийн олон наст ургамал тариалах, эдэлбэр газрын хашааг тойруулан мод, бут тариалж зурвас байгуулах ажлыг БОННУ болон БОМТ-ний хүчинтэй байх хугацаанд хийж гүйцэтгэх хэрэгтэй. Мөн доорх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Ашиглалтын үед гарах тоосжилтыг бууруулах үүднээс байгаль хамгаалах төлөвлөгөөнд заагдсан хугацаа, давтамжаар орчны агаар, хөрсийг чийгшүүлж байх;
- Автомашин, техникүүдийн янданд байрлах оч баригчуудыг сайтар шалгах;

- Ингэснээрээ техникийн яндангаас хаягдах очноос үүдэлтэй гал түймрээс урьдчилан сэргийлэх;
- Төслийн талбайд хийгдэх зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн ажлыг мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөгөө, мэргэжилтний оролцоотойгоор төлөвлөн хэрэгжүүлэх;
- Зүлэгжүүлэлтийг 6 сарын эхээр явуулж, үрийг суулгахдаа нарийн ширхэгтэй тармуураар мөр гаргасны дараагаар 1-3 см-ийн гүнд суулган, мөрийн дагуу шороогоор жигд хучих;
- Амьтдыг дайжиж үргэхээс сэргийлэн хүчтэй дуу чимээ гаргахгүй байхыг анхааруулах;
- Төслийн талбайн орчмын нутаг дэвсгэрт ан амьтны амьдрах орчныг бусниулахгүй, үргээхгүй, алж устгахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Тухайн бүс нутагт дулааны улиралд амрагч, аялагчдын тоо эрс нэмэгдэж төслийн талбайн ойр орчимд майхантай хонох, өдрөөр зугаалах зэрэг үйл ажиллагаа өргөнөөр явагддаг учир амрах цэгт гал түлэх, түүдэг гал асаах тохиолдолд газрыг 50-70 см хүртэл гүн, 2.5-3.0 метр диаметртэй талбайг ухаж хайрга, чулуун дүүргэвч хийж зориулалтын байдлаар тохижуулж ашиглуулах;
- Ил задгайгаар халуун үнс, нурам, цог үлдээх зэргийг хатуу хориглох шаардлагатай гэж үзвэл торгох хүртэлх арга хэмжээг авч, хяналт тавих;

НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ЗӨВЛӨМЖ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут нэмж тарих, ургамлан нөмрөгийг хамгаалах, нөхөн сэргээх нь тус төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

Ургамалжуулахад хялбар, арчилгаа бага шаардах болон зардал хямд нөхцлүүдийг тооцон олон наст ургамлууд болох ерхөг, согооворын үрийг суулгах нь илүү ач холбогдолтой байдаг. Ургамалжуулах талбай нь их биш бол гараар жигд цацаж гүйцэтгэнэ. Тариалалтыг хийхдээ цаг агаарын мэдээнээс салхи багатай өдрийг сонгож, үр хийсэхээс сэргийлнэ. Тарималжуулалтын ажлыг үндэсний стандартын дагуу хэрэгжүүлнэ.

- Суулгац тарих;
- Шаардлагатай гэж үзвэл усзүйн зохицуулалт хийх;
- Төслийн талбайн гадаргууг байгаль цаг уурын нөлөөгөөр эдлэгдэж эвдрэхгүй байхаар ойжуулах;
- Суулгацыг арчлах машин механизм ашиглах боломжтойгоор хөрс сайжруулах;
- Мод сөөгийг сонгон тарьж нутагшуулах;
- Тарималжуулалтын ажил хийгдсэнээр тухайн эвдрэлд орсон талбайд хүний амьдрал, үйл ажиллагаанд нийцсэн ландшафт бий болгож, ХАА-н ойжуулалтын зориулалтаар эргэлтэнд орж, үржил шим нь сайжирна
- Газрын нөхөн сэргээхэд ашиглах нилээд үр дүнтэй үндсэн ургамлууд нь бэлчээрийн олон наст ургамлууд болно. Үүнд:
 - Буурцагт ургамал: Царгас, хошоон, хошоонгор, төрөл бүрийн харгана
 - Модлог ургамлаас: Шинэс, Тарваган хайлаас, Шар хуайс
 - Олон наст, өвслөг ургамлаас: Ширэг, Улалж, Ерхөг, Согоовор

Хүснэгт 21. УРГАМАЛ ТАРИАЛАХ ХУГАЦАА

| Байгалийн бүс | Усалгаагүй нөхцөл | Усалгаатай нөхцөл |
|-----------------------|----------------------------|----------------------------|
| Уулархаг бүс | 6-р сарын 3 дахь 10 хоногт | 5-р сарын 3 дахь 10 хоногт |
| Ойт хээр, хээрийн бүс | 6-р сарын 2 дахь 10 хоногт | 5-р сарын 2 дахь 10 хоногт |
| Говь цөлийн бүс | 5-р сарын 3 дахь 10 хоногт | 5-р сарын эхний 10 хоногт |

Хүснэгт 22. УРГАМЛЫН ҮРИЙН НОРМ

| № | Ургамлын нэр Латин нэр 1 га-д (кг-аар) | Латин нэр | 1 га-д (кг-аар) |
|---|--|----------------|-----------------|
| 1 | Царгас | Medicago L | 8-10 |
| 2 | Хүцэнгэ | Onobrychis L | 25-30 |
| 3 | Зошооно | Melilotus Hill | 15-20 |
| 4 | Согоовор | Bromus L | 18 |
| 5 | Өлөнгө | Elymus L | 15-20 |
| 6 | Ерхөг | Gaertu | 15-18 |



4.5. Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Ахуйн хатуу хаягдлын цэгийг Хог хаягдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2017.05.12), түүнтэй нийцүүлэн гаргасан журам, аргачлал, зааврын дагуу ангилан ялгаж хуримтлуулах боломжтой, хөрсөнд бохирдол үүсгэхээргүй хөрснөөс тусгаарлагдсан, битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, байгалийн хүчин зүйлийн нөлөөнд өртөж хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байх шаардлагад нийцүүлэн 4 тасалгаа бүхий бетонон суурьтай, битүү тагтайгаар шинээр байгуулах;
- Хог хаягдлын цэгийн талбайг сонгохдоо салхины зонхилох чиглэлийн доор байр сууц, хоолны газраас 60м-с багагүй зайд, бие засах газраас тусад нь нэг цэгт байрлуулах ба хатуу хог хаягдлын цэгийг ялаа, шавж үржихээс сэргийлэн тогмол ариутгаж байх;
- Баазын гэр, байшингуудын орчимд хог хаягдлыг ангилан ялгах сав байрлуулах;
- Ангилан ялгасан хаягдлыг (шил, лааз, хуванцар, гялгар уут, цаас г.м) хаягдлыг дахиварын үйлдвэр, дахивар нөөцийн цэгт тушаах;
- Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг орон нутгийн тохижилт үйлчилгээний компанитай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн хаягдлын цэгт богино хугацаанд зайлуулах;
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
- Ахуйн шингэн хаягдлыг MBR ахуйн бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулан цэвэршүүлэх;
- Цэвэрлэгдсэн саарал усаар зүлэг ногоон байгууламж услах, бие засах газрын суултуурын усанд ашиглах зэргээр дахин ашиглах;
- Ариун цэврийн өрөөнүүдийн хаяг, тэмдэгийг тодоор хийж байршуулах;
- Техникийн шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн галын аюулгүй нөхцөлд ариутгах, эсвэл дарж булах байдлаар цэвэрлэх, саармагжуулах;
- Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцох;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
- Хог хаягдлын тухай хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;

Иргэн аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

- ♣ Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
- ♣ Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
- ♣ Хог хаягдлыг ил задгай шатаах;
- ♣ Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдал шатаах;
- ♣ Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
- ♣ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
- ♣ Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх;
- ♣ Хогийн сав галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал нь салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх зэрэг болно.

4.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

- ♣ Тусгай хамгаалалттай газар нутагт дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр орон сууц, үйлчилгээнд тавих шаардлага MNS 6426:2013 дугаар стандартыг барилга байгууламж, үйл ажиллагаа явуулахдаа мөрдлөг болгох;
- ♣ Хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилчдад анхааруулах, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах, нэгэнт гарсан тохиолдолд холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж, гал түймрийг богино хугацаанд унтраах аргыг ажилтнуудад эзэмшүүлэх;
- ♣ Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн гарах сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгахад шаардагдах зардлыг жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын биелэлтийг холбогдох газруудад тогтоосон хугацаанд тайлагнаж байх;
- ♣ Төслийн ажиллагсдад байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг тогтмол хийх;
- ♣ Төслийн ажилчид, аялагч амрагчид болон орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй хүлээн авч зохих хэмжээнд нь шийдвэрлэж заавал хариу өгөх;
- ♣ Баазын ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж байх;
- ♣ Бүх ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгөх;
- ♣ Анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах;
- ♣ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр), сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээний зөвлөмжид тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг тусгай ажилтанд хариуцуулж, биелэлтэд нь удирдлагын зүгээс тогтмол хяналт тавьж ажиллах;
- ♣ Улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, төлбөр, хураамжийг тогтоосон хугацаанд барагдуулж байх;
- ♣ Төслийн үйл ажиллагааны талаар тухайн орчинд ажиллаж, амьдарч буй иргэд, оршин суугчдад танилцуулах, үнэн зөв мэдээлэл өгч байх;
- ♣ Эдэлбэр газар шинээр барилга байгууламж барих, төслийн үйл ажиллагааг өргөтгөх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх;
- ♣ Батлагдаагүй зураг төслөөр барилга объект барих, зөвшөөрөлгүйгээр байгалийн үндсэн болон дагалт баялаг ашиглах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр болон мэргэжлийн бус байдлаар байгалийн баялагаас дээж авах, тухайн бүс нутагт

- оршин амьдрагч бус амьтдыг нутагшуулах, жуулчдыг батлагдаагүй маршрутаар аялуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглох;
- ✎ Байрлаж байгаа газрынхаа тухай мэдээлэл болон байгаль хамгаалах, хориглох үйл ажиллагааны талаар тусгагдсан мэдээллээр жуулчдыг үнэгүй хангаж, сурталчилж байх нь жуулчдын зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгана.
 - ✎ Баазын дэргэд зохих стандарт шаардлагыг хангахуйц багтаамж, доторлогоо бүхий хатуу хог хаягдал хуримтлуулах цэг байгуулан ариун цэврийн холбогдох нөхцлийн дагуу, газрын байршлын болон салхины чиглэлийн доод талд баазын объектуудаас ойролцоогоор 20 м зайд байгуулах;
 - ✎ Хуурай хог хаягдлыг таглаатай нийлэг эсвэл металл саванд хуримтлуулан тээвэрлэж байх (цаашид хуурай хог хаягдалгүй байх технологи нэвтрүүлэх), тамхи татах газрыг гал алдахааргүй тусгайлан бэлтгэх нь зүйтэй.
 - ✎ Хог хаягдлыг Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаатай (Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэстэй) хог тээвэрлэлтийн гэрээ байгуулан аль болох богино хугацаанд тогтмол зайлуулж байх шаардлагатай.
 - ✎ Үйл ажиллагаа явуулах хугацаанд гал түймрийн аюулаас хамгаалах үүднээс сургалт, сурталчилгаа явуулах, анхааруулах тэмдэг тэмдэглэл, санамж бичиг байрлуулах, гал унтраах тоног төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах нь зүйтэй.
 - ✎ Гал түймрийн аюулын үед авах арга хэмжээний талаар нийт ажиллагсадын дунд мэргэжлийн хүнээр тогтмол хугацаанд сургалт, яриа хийлгэн шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг болгосон байх шаардлагатай.
 - ✎ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг хоёр жил тутамд хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжинд заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны газар хүргүүлж байх;

4.7. Ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- ✎ Үйл ажиллагааны явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл, үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг авах;
- ✎ Үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;
- ✎ Хөдөлмөр эрхлэлтийн байдалд гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх;
- ✎ Хэт халуун буюу хүйтэн салхитай, хур тунадастай зэрэг задгай байранд халаалтгүй ажиллаж байгаа ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын дагуу түр завсарлагын үед амрах, дулаацах, хорогдох зориулалтаар тоноглож тохижуулсан байраар хангах;
- ✎ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;
- ✎ Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах;

- ▮ Төслөөс ажилчдын эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай.
- ▮ Ажлын зориулалттай хувцас, бээлий, амны хаалт, нүдний шилээр хангах, бүх ажилчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт тогтсон хугацаанд хамруулах;
- ▮ Техник хэрэгслийн хаалт хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах;
- ▮ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгааг тогтмол хийх;
- ▮ Ажилчдын гэнэтийн ослын үед үзүүлэх анхны тусламжийн шаардлагатай хэрэгслүүдээр хангаж, бэлэн байдалд байлгах;
- ▮ Галын аюулын үед хэрэглэх галын сарай, элс, хүрз, хувин, гал унтраах хөөс зэрэг шаардлагатай хэрэгслүүдээр хангах;
- ▮ Техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах, ажлын байрт гарч болзошгүй осол аваараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн зааварчилгаа өгөх;
- ▮ Шөнийн цагт ажлын байрыг сайтар гэрэлтүүлэх;
- ▮ Ажлын байрны нөхцөл нь ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, тэдний хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн, аюулгүй үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангахуйц байх;

4.8. Үйлчилгээний соёлч байдал, эрүүл ахуйн зөвлөмж

Амрагч, аялагчдыг тав тухтай, эрүүл, аюулгүй орчинд амраах, байгалийн дурсгалт зүйлс, өв соёлыг таниулан сэтгэл ханамжтай буцаах нь хамгаас чухал юм. Иймд үйл ажиллагаандаа доорх зөвлөмжүүдийг мөрдөж ажиллах нь зүйтэй.

- ▮ Үйлчилгээний соёл болон бусад тодорхой ур чадварын асуудлыг мэргэжлийн сургалтын хөтөлбөрөөр шийдвэрлэх буюу шаардлагатай үед үйлчилгээний ажилтнуудаа сургалтанд хамруулж мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх;
- ▮ Жуулчны улирал эхлэхээс өмнө байр байгууламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор зохих хөрөнгө оруулалт хийх;
- ▮ Амрагчдын байрлах гэр, байрны цэвэрлэгээ үйлчилгээ, хог хаягдал зайлуулах, хортон шавьжийн эсрэг хамгаалалт хийх зэрэг асуудалтай холбогдсон эрүүл ахуйн норм, дүрэм журмыг хатуу мөрдөж ажиллах;
- ▮ Гал тогоонд 3 дамжлагатай угаагуур хэрэглэх;
- ▮ Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээнд хэрэглэгдэх шүүр, алчуур, хувин, цэвэрлэгээний бусад хэрэгсэл нь зочдын гэр, буудлынхаас тусдаа, ялгах, таних тэмдэг тавигдсан байх;
- ▮ Угаалга, цэвэрлэгээ дуусмагц цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуурыг савантай усаар угааж, 1%-ийн хлормины уусмалаар ариутгаж байх;
- ▮ Өөрийн хүчин чадалд тохирсон ус цэвэршүүлэгчтэй болох;
- ▮ Рестораны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохион байгуулалт нь “Хоолны газрын үйлчилгээ” MNS-4946-2000 стандартын шаардлагыг хангаж байх ёстой.

ТАВДУГААР БҮЛЭГ.ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ

Эрсдэлийн үнэлгээ нь болзошгүй осол, аюулаас сэргийлэх менежментийн уян хатан арга хэлбэр бөгөөд тухайн төслийг хэрэгжүүлэхэд үүсэж болзошгүй осол аваари болон химийн бодисуудын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийх, эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөх, эрсдлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагаа юм.

Горхи-Тэрэлжийн БЦГ-т байрлах “Тэрэлж лож” жуулчны баазын хувьд явуулах үйл ажиллагаанаас үүдэн гарах осол аваари доорх байдалтай байна. Энэ нь аяллын үеэр хадан дээрээс жуулчид хальтрах, бие эрхтнээ гэмтээх, усанд живэх, хад чулууны нурангид даруулах зэргээр болгоомжгүй үйл хөдлөл, хөдөлгөөнтэй холбоотой осол гарч болзошгүй юм.

Иймд аялал, жуулчлалын замналыг зөв сонгон маршрутыг сонгон мөрдөх, аюул ослын үед хэрэглэх багаж төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах, энэ талаар сургалт явуулах зэргээр дээрх ослоос сэргийлэх арга хэмжээ авах, гарын авлага бэлтгэх шаардлагатай.

Төсөл хэрэгжих газар орчимд гарч болох байгалийн болзошгүй нэгэн осол жил бүр хавар, намрын хуурайшилтын үед гарч болох түймрийн нөлөөлөлд өртөж болох бөгөөд нөгөө талаар амралтын газар өөрөө ч гэсэн түймэр гарах нөхцөл болохыг үгүйсгэхгүй тул анхаарах нь зүйтэй юм.

Мөн агаарын даралтын хэлбэлзэл зарим өдөр 8-аас их байдаг тул зүрхний өвчтэй болон агаарын даралтын мэдрэмтгий хүмүүс болгоомжтой хандах хэрэгтэй. Хур тунадас зун хамгийн их тухайлбал 7 сард 300-350 мм орж, жилийн нийт хур тунадасны 60-70%-ийг эзэлдэг. Иймд аянга, аадар бороо, үер усны аюулаас жуулчны бааз, жуулчдыг хамгаалах талаар анхаарч аянга зайлуулагч, үерийн усны далан хийх хэрэгтэй юм.

Цахилгааны холболтод хэрэглэж байгаа утаснууд зохих аюулгүй ажиллагааны дүрэм журмын шаардлагыг хангаж байхаар хийхийн зэрэгцээ баазын гэрүүдийн хоорондох зайг цахилгаан хэрэгслүүдийн угсралт монтаж, галын аюулгүй ажиллагааны холбогдох журмыг бүрэн хангах байдлаар баримтлах хэрэгтэй.

Үйлчилгээний явцад гарч болзошгүй ослыг ахуйн болон байгалийн гэсэн үндсэн хоёр хэсэгт авч үзэв. Жуулчид, аялагчдын ая тухтай амрах нөхцлийг бүрдүүлэхэд үйлчилгээний чанарт ихээхэн анхаарах ёстой бөгөөд үүнд үйлчилгээний бүхий л хүрээ хамрагдана. Аялал жуулчлалын аливаа үйлчилгээ хот суурин газраас алс зайдуу, хээрийн нөхцөлд амрагчдыг хоол хүнс, цахилгаан хангамж, эрүүл ахуй, тохь тухыг хангах үүднээс бүхнийг эртнээс нарийн төлөвлөх учиртай. Энэ нь орон байр, үйлчилгээний тоног төхөөрөмж, ахуйн хаягдлын түр цэг, бараа материалын агуулахуудын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, амрах бүх нөхцлийг хангах зорилгоор зөв байрлуулж тоноглохоос эхэлнэ. Амралт, аялал жуулчлалын газрын ахуй нөхцөл, үйлчилгээний байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл нь харьцангуй бага ч зохион байгуулалтын талаас зохих анхаарал суларснаас хүмүүсийн хариуцлагагүй үйл ажиллагаатай уялдан төрөл бүрийн болзошгүй осолд хүргэж байгаль орчныг бохирдуулах, үйлдвэрлэл үйлчилгээний хэвийн ажиллагаа алдагдаж тоног төхөөрөмж эвдрэн, байгууллага санхүү, эдийн засгийн хохирол хүлээгээд зогсохгүй, хүний амь эрсдэх, хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болох зэрэг осол эндэгдэлд хүрч болохыг үгүйсгэж болохгүй.

Сургалт, сурталчилгаа хангалтгүйгээс байгаль орчноо бохирдуулах, устгах сүйрүүлэх аюулыг хүн өөрөө хормын зуур бий болгодгийг үйлчилгээ эрхлэгчид, жуулчин, амрагч хэн хүнд байнга сануулж байх хэрэгтэй.

Жуулчны баазын үйлчилгээний явцад гарч болзошгүй нөлөөллийг хүний эрүүл мэндэд харшилж болзошгүй нөлөөлөл, хүний бодлогогүй үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль экологийн тэнцвэр алдагдуулж болзошгүй нөлөөлөл, байгалийн гэнэтийн аюулын үед учирч болох болзошгүй нөлөөлөл зэрэг хүрээнд авч үзэх нь зүйтэй.

1.1. Хүний эрүүл мэндэд харшилж болзошгүй нөлөөлөл

Хүний эрүүл мэндэд харшилж болзошгүй нөлөөллийг хүмүүсийн эрхэлсэн ажилдаа хандах хандлага, удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаатай гол төлөв холбон авч үзнэ. Үйлчилгээний үйл ажиллагаатай уялдан дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд:

- Цахилгаан үүсгүүр болон ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийг мэргэжлийн бус хүмүүс дур мэдэн засаж сэлбэхийг оролдсоноос;
- Цахилгаан тоног төхөөрөмжийн холболтын гэмтлийг тухай бүр нь илрүүлж шалгаж засаагүйгээс;
- Согтуу хөлчүүгээр машин, тоног төхөөрөмжтэй харьцаж дүрэм зөрчсөнөөс;
- Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ аваагүй, эсвэл аваагүй байхад яаравчлан ажилд орсноос;
- Ажил эхлэхийн өмнө техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг анхаарч шалгаагүйгээс;
- Хад асгаар анхаарал болгоомжгүй явснаас;
- Мэргэжиж дадаагүй ажлыг удирдлагын заавар зөвшөөрөлгүй бусдын гуйлт, хүсэлт буюу дур мэдэн хийж гүйцэтгэснээс;
- Зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын ажилтнаас бусад галт(буу г.м) зэвсэг эзэмших эрхгүй хүмүүс түүнтэй анхаарал болгоомжгүй харьцсанаас;
- Хүнсний зүйл, тэдгээрийн хадгалах хугацаа хэтэрсэн болон муудсан бүтээгдэхүүн хоол хүнсэнд хэрэглэснээс;

ЖУУЛЧИД, АМРАГЧИД, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, АМЬ НАСАНД ХҮРЧ БОЛЗОШГҮЙ ДЭЭРХ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙН ТУЛД:

- Үйлчилгээнд ашиглах бүх төрлийн машин техник, ахуйн цахилгаан үүсгүүр тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн байгууллагаар урьдчилан шалгуулж үнэлэлт дүгнэлт гаргуулж зохих зөвшөөрөл авсан байх;
- Тоног төхөөрөмжийг зөв угсарч, үйлчилгээ явуулах, ашиглахад хамгийн тохиромжтой байрлалд бат бэх суурилуулж бэхэлсэн байх;
- Ялангуяа цахилгааны эх үүсгүүр, машин тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах техник аюулгүйн дүрмийг ажиллагсдад ойлгуулж, чанд мөрдүүлэх;
- Ажил, үйлчилгээний үед согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглож, хяналт тавьж ажиллах;
- Үйлчилгээний ажилчид болон жуулчны баазын газарт үйлчлүүлэгчдээс мөрдөх дотоод дүрэм журам боловсруулж батлан мөрдүүлэх;
- Цахилгаанаар ажилладаг ахуйн хэрэглээний тоног төхөөрөмжийн холболтыг мэргэжлийн өндөр түвшинд шаардлага хангахуйц материалаар(холболтын утас,

- холбоос, залгуур г.м.) тоноглож мэргэжлийн байгууллагаар(эрх бүхий мэргэжлийн хүмүүс)-аар хянуулж зөвшөөрөл авахын зэрэгцээгээр байнгын хяналт тавьж байх;
- Ээлжийн ажилтай ажилчдыг улируулан ажиллуулахгүй байх;
 - Бололцоотой бол зуны ачаалал ихтэй хугацаанд эмч ажиллуулах;
 - Үдэш орой шөнийн цагаар гэнэдэж төөрсөн хүмүүст анхааруулга, дохио өгөх дохиоллын тоног төхөөрөмжтэй байх;
 - Үдэш орой тодорхой цагаас хойш баазаас дур мэдэн гадагш гаргахгүй байх хуваарь гаргаж мөрдүүлэх;
 - Осол эндэгдэлд өртсөн хүмүүст анхны тусламж үзүүлэх арга барилыг үйлчлэгчдэд эзэмшүүлсэн байх;
 - Шаардлагатай үед ойр дөт хот, суурингаас эмч дуудах нөхцлөөр хангагдсан холбооны хэрэгслэлтэй байх;

1.2. Байгаль-экологийн тэнцвэрийг алдагдуулж болзошгүй нөлөөлөл

“Тэрэлж лож” жуулчны баазын төсөл хэрэгжүүлэх явцад хүмүүс байгаль орчинтойгоо хайнга харьцсанаас байгаль нь гадны нөлөөнд нэн хялбар өртөж алдралд орох, улмаар амьд байгаль дахин сэргэхгүйгээр устгах, байгалийн унаган төрх өөрчлөгдөж түүний хөгжлийн хэвийн жам алдагдан ойр орчиндоо дам нөлөөлдөг байгалийн хууль, зүй тогтлыг мэдэхгүйгээс байгальд тоомсоргүй хандах нь элбэг байдаг. Үүнтэй уялдан экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, наад зах нь төслийн хүрээнд харгалзан үзсэнээс хавьгүй их сөрөг нөлөө үзүүлдэг. Байгаль-экологийн тэнцвэрийг алдагдуулж болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлсүүд орно. Үүнд:

- Байгалийн хүчин зүйлүүдийг дутуу үнэлснээс
- Байгаль орчныг хэт бохирдуулснаас
- Нэн ховор, ховор ургамал сэргээгдэхгүй устгаснаас
- Гадаргын болон хөрсний усны горим өөрчлөгдсөнөөс
- Гал түймэрт өртсөнөөс
- Ан амьтныг зүй бусаар үргээж, алж устгаснаас
- Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлыг анхаараагүйгээс

Энэ бүхэн нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан зөвлөмжүүдэдийг хэрэгжүүлээгүйгээс үүдэж болно. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын Орог ямаатын өвөр нэртэй газарт орших “Толин хул” амралт, аялал жуулчлалын цогцолборын орчны байгальтай ажилчид, аялагчид нутгийн иргэд болгоомжтой харьцаж аливаа бохирдол, эвдрэлээс хамгаалж чадвал нөхөн сэргээгдэх боломжгүйгээр устгах, эвдрэлд орох сөрөг нөлөөллөөс сэргийлэх боломжтой. Ийнхүү экологийн тэнцвэрт байдлыг алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг авах хэрэгтэй. **ҮҮНД:**

- ▮ Хөрс, хөрсний усыг бохирдуулахгүй байх;
- ▮ Орчны бут сөөг, бусад ургамлыг гэмтээж устгахгүй байх;
- ▮ Алдрал, эвдрэлд өртсөн хөрс, ургамлыг байнга нөхөн сэргээх;
- ▮ Хөрс, ургамал нөмрөгийг талхлахгүй байх;
- ▮ Гал түймэр алдах бүх бололцоо нөхцлийг хаах;
- ▮ Ахуйн аливаа хог, бохир усыг ил задгай орхихгүй байхаас гадна энэхүү тайланд тусгагдсан заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

1.3. Байгалийн гамшигт үзэгдлийн гаралтай эрсдлийн үнэлгээ

Төсөл хэрэгжих газар нутгийн газарзүй, ландшафтын тогтоц, байгаль цаг уурын онцлогоос хамаарч аянга цахилгаан, үер, ган, гал түймэр, газар хөдлөл зэрэг байгалийн гаралтай гамшгийн эрсдэл бий болж цахилгаан шугам сүлжээ гэмтэх, барилга байгууламж үерт автах, гүний усны түвшин буурах зэрэг эрсдэлтэй.

Аянга цахилгаан: Төсөл хэрэгжих талбай болон түүний нөлөөллийн бүсэд сүүлийн 10 жилийн хугацаанд аянга бууж байгаагүй болно. Харин дуу цахилгаантай бороо зуны улиралд 10-12 хоног байдаг. Аянга нь агаар мандлын орон зайд хуримтлагдсан усны уурын хэсгүүд агаартай үрэлт үүссэний улмаас цэнэгжин агаар мандалд цахилгаанжилт бий болдог. Энэхүү цэнэг нь тодорхой нөхцөлд, тодорхой утгад хүрэхдээ асар их хэмжээний ниргэлтийг бий болгож, хурц гэрэл, дуу гаргана. Аянга ниргэлтийн үед гүйдлийн хүчний хэмжээ 15000000 В, гүйдлийн хэмжээ 200000 А-т хүрч 6000-100000С дулаан ялгаруулдаг. Ниргэлтийн хурд нь 100000 км/с, ниргэлтийн үргэлжлэх хугацаа нь 0.1-1 сек явагдана.

Аянга цахилгааны ослоос урьдчилан сэргийлэхийн тулд төслийн талбайд аянга зайлуулагч, газардуулагчийг мэргэжлийн байгууллагаар суурилуулах шаардлагатай.

Үер: Үер гэдэг нь гол мөрний усны түвшин хэвийн хэмжээнээс дээшлэх савнаасаа хальж, урсгал нь хэт түргэсэх, хуурай сайр, жалга, далан усны хүчтэй түрэлт, урсгал бий болгохыг хэлнэ. Үерийг гол мөрний, шар усны, уруйн гэж ангилан үздэг. Төслийн талбайд уруйн болон шар усны үер болох боломжтой.

ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖ:

- Төслийн талбайн барилга байгууламжийг тойруулан үерийн ус зайлуулах суваг шуудуу татах;
- Хавар амралтын газрын үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажлын үе шатанд их бороо орох тохиолдол үйл ажиллагааг зогсоох;
- Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол хүлээн авах;
- Төслийн талбайд үерийн ус зайлуулах шугам хоолойг батлагдсан зураг төслийн дагуу мэргэжлийн байгууллагаар бариулах;
- Амрах байрууд болон барилгын гадна талд ус зайлуулах шугам хоолой гаргаж ус хуримтлуулах;
- Хур тунадас элбэгтэй жил гүний усны түвшин нэмэгддэг тул барилга байгууламжийг нарийн төлөвлөгөөтэй барих цаашид үүсэх эрсдлийг нарийн төлөвлөж барьж байгуулах хэрэгтэй.

Гал түймэр: Гал түймэр гэж хүний амь нас, эрүүл мэнд хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шалтгааныг хэлдэг. Харин гал түймрийн гамшиг гэж объектын болон ой, хээрийн гал түймэр өргөжин дэлгэрч олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох байгалийн баялаг их хэмжээгээр сүйрэхэд хүргэх нөхцөл байдлыг хэлдэг.

Манай оронд ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа нь жил бүрийн 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10 ны өдөр хүртэлх хугацааг түймрийн аюултай үе гэж хуульчилсан байдаг. Төсөл хэрэгжих 15.76 га талбайд хээрийн болон объектын түймэр гарч болзошгүй.

Манай орны байгалийн гамшгийн эрсдэлийн болон эмзэг байдлын үнэлгээнээс үзэхэд ой-хээрийн түймэр 1-5 жилд нэг удаа гарах магадлалтай боловч хүмүүсийн болгоомжгүй үйлдлээс шалтгаалан ямар ч үед гал түймэр гарч болзошгүй учраас гал

түймрээс бүхий л талаар урьдчилан сэргийлж, галын болзошгүй аюулд өртөхөөс болгоомжилж байх шаардлагатай.

Иймд төсөл хэрэгжүүлэгч “Планет интернэшнл” ХХК нь аюулгүй байдлаа сайн хангаж, ажилчдад гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдол өөрийгөө болон бусдыг хамгаалах, унтраах арга хэмжээнүүдийн талаарх холбогдох байгууллагын мэргэжилтнүүдээс сургалт, зөвлөгөө авах шаардлагатай. Ингэснээрээ төслийн талбайд гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авах боломжтой болно. Гал түймрийн гэнэтийн ослын үед ашиглах гал унтраах бүх төрлийн хэрэгслийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага бэлтгэж байнгын бэлэн байдалд байлгах шаардлагатай.

ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ:

- ▮ Төслийн барилга байгууламжид гал гарах үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;
- ▮ Гал гарсан үед аваарийн орц, гарцыг тэмдэглэж байршлын схемийг барилгуудад ил хадах;
- ▮ Тус төлөвлөгөөт ажилчдад танилцуулж сургах гал унтраах багаж хэрэгслээр хангах;
- ▮ гал унтраах багаж, төхөөрөмж, гал унтраах бүх төрлийн хэрэгслүүдийг суурилуулан ажиллагааг хэвийн байлгах;
- ▮ Ажилчдыг галын хор болон бусад багаж хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулах арга хэмжээг авах;
- ▮ Ажилчид машин техникийн засвар үйлчилгээний бүс, ахуйн газ байрлаж буй газар зэрэг тэсэрч дэлбэрэх аюултай газарт тамхи татах болон татсан тамхины ишийг ил задгай хаяхыг хатуу хориглох;
- ▮ Барилгын аюулгүй байдлыг төрийн хяналтын болон мэргэжлийн байгууллагаар шалгуулж дүгнэлт гаргуулах;
- ▮ Барилгын өрөөний хаалгууд гадагшаа нээгдэж байхаар төлөвлөж суурилуулах;

Салхи, шуурга: Төсөл хэрэгжих газар нутагт хавар намрын улиралд хүчтэй салхитай өдрийн тоо 6-10 хоног байдаг. Салхины зонхилох чиглэл баруун хойноос зүүн өмнөд рүү салхи салхилна. Төсөл хэрэгжих газар нутагт салхины үнэмлэхүй хурд 15-19 м/с хүрч хүчтэй шуурдаг.

Хүснэгт 23. Салхины хурдаас хамаарч үүсэх нөлөөлөл

| Салхины хурд, м/с | Учруулах нөлөөлөл |
|-------------------|--|
| 5-10 | Сул шороо тоос агаар мандалд тархаж явган шуурга эхэлнэ. Усан дээр долгион үүснэ. |
| 10-15 | Модны бүдүүн мөчрүүд савлана. Нарийн мод бүхэлдээ ганхана. Шинэ орсон цас хийсэж, зөөгдөн хунгарлана. |
| 15-18 | Модны нарийн мөчрүүд хугарч, салхи сөрж явахад төвөгтэй болно |
| 18-22 | Байшингийн дээвэр хуурна. Хөрс шороо хийснэ. |
| 22-25 | Модыг үндсээр нь булга татна. Гэр, хөнгөн хийц бүхий байшин, хашаа, саравч нурна. Шороо их хэмжээгээр хийсч, хөрс эвдэрнэ. |
| 25-29 | Гэр байшин барилгад багагүй эвдрэл гарна. Шороо их хэмжээгээр хийсч, хөрс эвдэрнэ. |
| 30< | Асар их эвдрэл үүснэ. Шороо их хэмжээгээр хийсч, хөрс эвдэрнэ. |

Салхи шуургатай үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ▮ Барилга байгууламжийн бэхлэгээг байнга шалгаж, урсгал засвараа сайжруулан засч байх;
- ▮ Барилгын гаднах цахилгаан утас, түүний холбоосуудыг байгалийн энэ үзэгдэлтэй уялдуулан аюулгүй талаас нь байнга шалгаж засварлаж байх;

Газар хөдлөл: Улаанбаатар хотод газар хөдлөлийн идэвхтэй 3 хагарлын бүс байдаг. Үүнд:

1. Хустайн хагарал нь УБ хотын төв цэгээс баруун өмнө зүгт 30 орчим км зайнаас азимут нь Зүүн хойноос-Баруун өмнө чиглэлтэй сунан тогтсон. Энэ нь 1250 онд хөдөлсөн ба 2-3000 жилийн дараах давтагдалтай Хамгийн хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдол Mw 7.6

2. Эмээлтийн хагарал нь УБ хотоос Баруун урагш 15 орчим км-ээс Баруун хойш-Зүүн өмнө чиглэлтэй сунаж тогтсон 2005 оноос хойших чичирхийллийн бүртгэлээс үзвэл бичил газар хөдлөлт болж байгаа. Энэ хагарал 550 жилийн өмнө хөдөлсөн ба дараагийн хөдлөх хугацаа нь дөхсөн байгаа гэж үзэж байна. Хамгийн хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдол Mw 6.6

3. Гүнжийн хагарал: УБ хотоос зүүн хойш 5 км орчмоос зүүн хойш суналттай одоогоор 2 удаа хөдөлсөн нь тогтоогдсон байна. Төсөл хэрэгжих газар нь одоогийн манай улсад мөрдөгдөж буй 1985 оны Монголын газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зургаар 8 баллын газар хөдлөлтийн бүсэд багтдаг. Төслийн талбай нь **Гүнжийн хагарлын бүсэд** хамаарна.

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ:

- ▮ Газар хөдлөлтөд тэсвэртэй барилга байгууламж барих;
- ▮ Жил бүрийн гамшгийн эсрэг өдөр газар хөдлөлтийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг ажилчдад үзүүлэн сургалт явуулж чадваржуулах;
- ▮ Газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдэхэд бие хамгаалж цахилгаан сүлжээг салгах;
- ▮ Гамшгийн үед нэн чухал замыг тодорхойлох;
- ▮ Газар хөдлөлтийг богино хугацаанд мэдээлэх аваарийн системийг байрлуулах;
- ▮ Амралтын газрын барилгыг газар хөдлөлтөд тэсвэртэй Барилгын явцад хяналт шалгалт тогтмол хийлгэх, мониторинг хэрэгжүүлэх;
- ▮ Дотоод засал өрөөний хаалга зэргийг газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй байхаар барьж байгуулах;

1.4. Төслийн техник технологиос үүдэлтэй эрсдэл

Амрагч, жуулчдын тав тухтай үйлчлүүлэх нөхцлийг хангахад үйлчилгээний чанарт ихээхэн анхаарах ёстой бөгөөд үүнд үйлчилгээний бүхий л хүрээ хамрагдана. Энэ нь аялал, жуулчлалын цогцолборын барилга, гэр сууц болон үйлчилгээний тоног төхөөрөмж, ахуйн хаягдлын цэг, бохирын цооног, бараа материалын агуулахын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, үйлчлүүлэх бүх нөхцлийг хангах зорилгоор зөв байрлуулахаас эхэлнэ.

Төслийн ахуйн нөхцөл, үйлчилгээний байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл нь харьцангуй бага ч зохион байгуулалтын талаас зохих анхаарал суларснаас хүмүүсийн хариуцлагагүй үйл ажиллагаатай уялдан төрөл бүрийн болзошгүй осолд хүргэж байгаль орчныг бохирдуулах, үйлчилгээний хэвийн ажиллагаагаа алдагдаж тоног төхөөрөмж эвдрэн, байгууллага санхүү, эдийн засгийн хохирол хүлээгээд зогсохгүй, хүний амь эрсдэх, хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болох зэрэг осол эндэгдэлд хүрч болохыг үгүйсгэж болохгүй. Сургалт, сурталчилгаа хангалтгүйгээс байгаль орчноо бохирдуулах,

устах сүйрэх аюулыг хүн өөрөө хормын зуур бий болгодгийг амрагч, үйлчлүүлэгчдэд байнга сануулж байх хэрэгтэй.

Техник технологитой холбоотой эрсдэлүүд:

- ▮ Цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулах систем зэрэг нь хамгийн их эрсдэл бүхий хэсэг бөгөөд хэрвээ техникийн горим, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөн тохиолдолд ноцтой эрсдэл, аюул учруулж болзошгүй.
- ▮ Явган аяллын үед анхаарал болгоомжгүйн улмаас хад, чулуунаас унаж гэмтэх
- ▮ Гал тогооны хэсэгт тог цахилгаантай буруу харьцсанаар цахилгаанд цохиулах
- ▮ Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй биеийн тамирын тоног төхөөрөмжид хяналт, шалгалт хийхгүй удсаны улмаас үйлчлүүлэгчид ашиглах үед бэртэж, гэмтэх
- ▮ Өөрийн гүйцэтгэх ажлаас өөр ажлыг удирдлагын заавар зөвшөөрөлгүй өөрийн дураар хийж гүйцэтгэх
- ▮ Хүнсний зүйл болон бусад бүтээгдэхүүнийг хадгалахдаа зориулалтын бус газар буруу хадгалах г.м

ИЙМД ТЕХНИК ТЕХНОЛОГИТОЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДАРААХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ. ҮҮНД:

- ▮ Амралтын цогцолборт мөрдөн ажилладаг аюулгүй ажиллагааны дүрэм батлан мөрдүүлэх;
- ▮ Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтантай байх эсвэл хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх сургалтад суусан ажилтан хавсарч хийж болно.
- ▮ Аюулгүй ажиллагааны арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төлөвлөсөн байх;
- ▮ Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг ажлын байр тус бүрт хийдэг байх;
- ▮ Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй байх;
- ▮ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай байх зааварчилга өгдөг байх;
- ▮ Ажлын хувцас хамгаалах хэрэгслийн хэрэглүүлж хэвшүүлсэн байх;
- ▮ Үйлдвэрлэлийн осол, судлан бүртгэдэг орон тооны бус комисстой байх;
- ▮ Осолд өртсөн тохиолдолд болон ослыг судлан бүртгэдэг, Налайх дүүргийн МХГ болон Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар мэдээлдэг байх;
- ▮ Үйлчилгээнд ашиглах бүх төрлийн машин техник, ахуйн цахилгаан үүсгүүр тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн байгууллагаар урьдчилан шалгуулж үнэлэлт дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авсан байх
- ▮ Тоног төхөөрөмжийг зөв угсарч, үйлчилгээ, явуулах, ашиглахад хамгийн тохиромжтой байрлалд бат бэх суурилуулж бэхэлсэн бай
- ▮ Ялангуяа цахилгаан эх үүсгүүр, машин тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах техник аюулгүйн дүрмийг ажиллагсдад ойлгуулж, чанд мөрдүүлэх
- ▮ Ажил үйлчилгээний үед согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглож, хяналт тавьж ажиллах зэрэг болно.

ЗУРГААДУГААРБҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

“Планет интернэшнл” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Тэрэлж лож” жуулчны баазын БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-05 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу уг төслийн БОННУ-ний тайланд үндэслэн боловсруулав.

БОННУ болон БОМТ нь 5 жилийн хугацаанд буюу 2022 оноос 2026 оныг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

Уг төслийн БОМТ нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой юм. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд БОННУ, БОМТ-ний хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанд (2019-2023 он) “Толин хул” амралт, аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагааны үед шатуудад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд хийж гүйцэтгэх ажлууд, хяналт шинжилгээ хийх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа болон зардлын хамт тусгасан болно.

БОННУ-нд хамрагдаж буй уг төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнд 2022-2026 онд нийт **28800.0** мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарсан байна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар жилд 200.0 мян.төг зарцуулахаар байна. “Тэрэлж лож” жуулчны баазын орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 2022-2026 онд нийт 1000.0 мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарлаа.

Харин Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох, Түүх соёлын өвийг хамгаалах ажлууд хийгдэх шаардлагагүй гэж үзсэн тул төлөвлөгөөг нь боловсруулаагүй болно. Энэхүү урьдчилсан байдлаар төсөвлөсөн зардлын төсөвт төсөл хэрэгжүүлэгч жил бүр тодотгол хийж тус тайлангийн хүчинтэй байх хугацаанд жил бүрийн ТЖБОМТ-г боловсруулан БОАЖЯ-аар батлуулан хэрэгжүүлэх, төсөв зардлыг төслийн төлөвлөлтийн зардалд төвлөрүүлж байх шаардлагатай.

6.2. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 24. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Төслөөс үзүүлэх нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа, төсөв, мян.төг | | | | | Аргачлал, стандарт |
|---|---------------------------------------|---|-------------------------------------|--------------|--------------|--------------|--------------|--|
| | | | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | |
| 1. Агаар | | | | | | | | |
| 1 | Дуу шуугиан | Төслийн үйл ажиллагааны үед хэт чанга дуу авиатай олон цаг үргэлжилсэн арга хэмжээ зохиохгүй байх дуу шуугианыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах | - | - | - | - | - | Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдаагүй ерөнхий шаардлага. MNS 5010-2000 Дуу, шуугиан. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5002: 2000 Доргион. Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 4995: 2000 |
| 2 | Тоосжилт | Төсөл хэрэгжих талбайд хэт тоосжилт үүсэхээс сэргийлэх, цаг агаарын хуурай нөхцөлд шороон болон хөрсөн гадаргууг чийгшүүлж байх | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | |
| 3 | Хорт хий | Тээврийн хэрэгслийг удаан асаалттай байлгахгүй байх Хүчин чадлаас хэтэрсэн үйлчилгээ явуулж хүн, машин техникийн бөөгнөрөл үүсгэж агаар орчинг бохирдуулахаас байнга сэргийлэх, Ашиглаж буй машин техникт сайн чанарын түлш ашиглах | - | - | - | - | - | |
| 4 | | Хатуу хог хаягдлын сав, болон түр цэгийг барилга байгууламж болон үйлчлүүлэгчид ажилчдын байрнаас дор хаяж 60м зайтай, зонхилох салхины доор байрлуулах | - | - | - | - | - | |
| Дүн | | | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | |
| 2. Газар, хөрсний эвдрэл, бохирдол | | | | | | | | |
| 1 | Хөрс бохирдох | Баазын үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмжөөс гарах хатуу болон ахуйн хуурай хог хаягдлыг эмх цэгцтэй хадгалах, ангилах, тээвэрлэх | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Ариун цэврийн тухай хууль |
| 4 | Хөрс элэгдэх, эвдрэх | Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбар байрлуулах, тэмдэгжүүлэх | 100.0 | - | - | - | - | |
| 7 | Газрын төлөв, хөрс, ургамлын өөрчлөлт | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх | - | - | - | - | 2000.0 | Газрын тухай хуулийн 28-р зүйл |

| | | | | | | | | |
|-----------------------------------|--|---|---|-------|-------|-------|--------|--|
| Дүн | | | 1600.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 2100.0 | |
| 3. Амьтан, ургамлан нөмрөг | | | | | | | | |
| 1 | Хөрс, ургамлан нөмрөг доройтох | Төв замаас амралт хүртэл зөвхөн нэг замтай байлгах, үүний тулд тэмдэгжүүлэх | - | - | - | - | - | “Тусгай хамгаалалттай газар нутагдахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013 стандартыг мөрдөх |
| 3 | | Авто замын дагуу 500-1000 м-ийн зайд хаяг, замын тэмдгийг байршуулах, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоолыг байр, сууцнаас 200 м-ээс багагүй зайд байрлуулж тэмдэгжүүлэх, явганы замаас өөр газраар явахыг хориглосон самбар байрлуулах | - | - | - | - | - | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэм хувцас. Ерөнхий шаардлага MNS 5851 : 2008 |
| 4 | Зэрлэг ан амьтдын тархац нутгийг хумих | Амрагч, жуулчдад зэрлэг ан амьтдын талаар мэдээлэл өгч орчинтой танилцуулах, дуу чимээ бага гаргах, амьтдыг айлгаж цочоохгүй байх талаар анхааруулах брошур тарааж өгөх | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэм хувцас. Ерөнхий шаардлага MNS 5851 : 2008 |
| 5 | Эвдэрсэн газрын биологийн | Эдэлбэр газрын 20 хувиас багагүй талбайд ногоон байгууламж байгуулан арчилгаа тордолт хийх | 200.0 | 200.0 | - | - | - | Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS |
| 6 | нөхөн сэргээлт | Мод , сөөг тарих | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 5918:2008 |
| Дүн | | | 500.0 | 500.0 | 300.0 | 300.0 | 300.0 | |
| 4. Усан орчин | | | | | | | | |
| 1 | Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах | Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах мөн ус ашиглах дүгнэлтийг жил бүр гаргуулах | 260.0 | 260.0 | 260.0 | 260.0 | 260.0 | Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам |
| 2 | | | | | | | | Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс |
| 3 | Гүний усны | | | | | | | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Татварын хэлтэст төлөх |
| 4 | бохирдлоос сэргийлэх | Гүний худагт эрүүл ахуйн бүс тогтоох | Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлэх | | | | | |
| 5 | Төлбөр хураамж | Усны нөөц ашигласны төлбөр | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | |
| 6 | Стандартад нийцсэн усаар хангах | Худгийн усны чанар, найрлагыг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх | Хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардалд орсон | | | | | |
| Дүн | | | 360.0 | 360.0 | 360.0 | 360.0 | 360.0 | Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага түүнд тавигдах хяналт. MNS 0900:2010 |
| 5. Хог хаягдал | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|--|--|--------------|--------------|--|--------------|--------------|--|
| 1 | Ахуйн хатуу хог хаягдлаар орчныг бохирдуулах | Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, Налайх дүүргийн ТҮК-тай гэрээ байгуулж аль болох богино хугацаанд төслийн талбайгаас тогтмол зайлуулж байх. Хатуу хог хаягдлыг шатааж устгахыг хатуу хориглох, ахуйн хог хаягдлыг богино хугацаанд зайлуулах | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Хог хаягдлын тухай хууль Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам |
| 2 | | Суваг шуудуу, бохирын траншей, хогийн цэгийн байрлалыг хөрсний усны түвшин, гадаргын хэвлий зэрэгтэй уяалдуулан зөв сонгох (объектээс 60м ээс багагүй зайд зонхилох салхины доод хэсэгт | - | - | - | - | - | |
| 3 | | Хог хаягдал гаргасны төлбөр | 60.0 | 60.0 | 60.0 | 60.0 | 60.0 | Хог хаягдал гаргасны төлбөр хог хаягдлын гэрээгээр |
| 4 | | Төслийн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрснийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх, ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах | - | - | - | - | - | |
| 5 | Дахин ашиглах | Дахивар хогийг ангилж цуглуулан хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах | 80.0 | 80.0 | 80.0 | 80.0 | 80.0 | - |
| 6 | Шингэн хаягдал | Цэвэрлэх байгууламжийн лагийг 0.8 хувьд хүрэхэд мэргэжлийн байгууллагаар шалгуулах | 200.0 | 200.0 | - | - | - | - |
| | | Ахуйн шингэн хаягдлыг MBR технологийн цэвэршүүлэх төхөөрөмжөөр цэвэршүүлж хөрс бохирдуулахгүй байх | - | - | Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлэх | | | |
| 7 | | Ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдлыг “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” MNS 4943: 2015 стандартад нийцүүлэн зайлуулах | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS4943: 2015 |
| | | Дүн | 690.0 | 690.0 | 490.0 | 490.0 | 490.0 | |
| 6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | | | | | | | | |
| 1 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт | Налайх дүүргийн БОГ-т жилд 1 удаа танилцуулах | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам |
| 2 | | 6-р хорооны ИНХ-д жилд 1 удаа танилцуулах | | | | | | |
| Дүн | | | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | |
| 7. Удирдлага зохион байгуулалт | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|----|--|---|--|--------|--------|--------|--------|---|--|
| 1 | ХАБЭА | Байгаль орчныг хамгаалах ХАБЭА-н талаар сургалт зохион байгуулах | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам | |
| 2 | | ХАБЭА-н дүрэм зааврыг мөрдөж ажиллах | - | - | - | - | - | | |
| 3 | Аюул осол | Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | | |
| 4 | Хууль эрх зүйн орчин | Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх | - | 4000.0 | - | 4000.0 | - | | |
| 5 | | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх | БОМТ-ий газар, хөрсний эвдрэл, бохирдлыг бууруулах зардалд орсон | | | | | | |
| 6 | | БОМТөлөвлөгөө болон биелэлтийн тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд нь өгөх, олон нийтэд танилцуулах | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам | |
| 7 | | Амралтын газрын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, гэрээнүүд/ газар ашиглах, ус ашиглах гэрээ, хог тээвэрлэлтийн гэрээ, ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт г.м/-ийг цаг хугацаанд нь чанартай биелүүлж дүгнүүлэх, сунгах, холбогдох төлбөр тооцоог хийх | - | - | - | - | - | Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүй | |
| 8 | Сөрөг нөлөөллийг бууруулах бусад арга хэмжээ | Усыг хэмнэлттэй ашиглах заавар санамж байрлуулах, иргэдэд танилцуулах | 1000.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 | “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх” тухай ЗГ-ын 326-р тогтоол Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943: 2015 Аюултай хог хаягдлын жагсаалт батлах тухай, Засгийн газрын 2013 оны тогтоол Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013 стандартыг мөрдөх | |
| 9 | | “Толин хул” амралт, аялал жуулчлалын цогцолбор нь өөрийн хүчин чадалд тохирсон цэвэрлэх байгууламжтай болох цэвэрлэх байгууламжаас гарах цэвэршүүлсэн усыг нөхөн сэргээлт, ариун цэврийн өрөөний ус таталтанд дахин ашиглах | | | | | | | |
| 10 | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах арга хэмжээ авах , ахуйн гэрлийн шил, халуун сав, төрөл бүрийн батарей, хүнд металл бүхий эд хэрэгсэл зэрэг уурших, исэлдэх чанартай, аюултай, хортой хог хаягдал бага хэмжээгээр гарч болно. Иймд эдгээр хаягдлыг тусад нь хурааж зайлуулах | | | | | | | |
| 11 | | “Тэрэлж лож” аялал жуулчлалын баазыг стандартад нийцсэн, оршин суугчдад тав тухтай орчин бүрдүүлж үйлчилгээ үзүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|-----|---|---------------|---------------|---------------|---------------|---------------|---|
| 12 | Байгаль хамгаалах тухай хууль болон бусад хууль эрхзүйн хүрээнд мод тарих ажлыг жил бүр зохион байгуулж, үр дүнг хамгаалалтын захиргаанд хүлээлгэж өгөх | | | | | | Байгаль орчныг хамгаалах тухай хууль |
| 13 | Байгалийн унаган төрхийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулж байгаль хамгаалах зардлын 50%-ийг тусгай дансанд байршуулах, хамгаалалтын захиргааны үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах | | | | | | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, нөхөн сэргээлтийн тусгай дансны журам |
| 14 | Төслийн ажилчид болон амрагчдад хог хаягдал ил задгай хаяхгүй байх, усыг зөв зохистой ашиглах, БЦГ-т аялаж зугаалахдаа болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослын үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах, уриалга гаргах, амралтын газрын орчимд анхааруулах самбар байршуулах зэрэг арга хэмжээ авах | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | - |
| Дүн | | 1800.0 | 5800.0 | 1800.0 | 5800.0 | 1800.0 | |
| | Нийт дүн, мян.төг | 5200.0 | 7700.0 | 3300.0 | 7300.0 | 5300.0 | |



Хүснэгт 25. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв, мян.төг

| № | Зардлын ангилал | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он | 2026 он |
|---|---|--|---------------|---------------|---------------|---------------|
| 1. | Агаар орчныг бууруулах | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 |
| 2. | Газар, хөрсний эвдрэл, бохирдол | 1600.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 2100.0 |
| 3. | Амьтан, ургамал | 500.0 | 500.0 | 300.0 | 300.0 | 300.0 |
| 4. | Усан орчин | 360.0 | 360.0 | 360.0 | 360.0 | 360.0 |
| 5. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 690.0 | 690.0 | 490.0 | 490.0 | 490.0 |
| 6. | Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө | Химийн бодис хэрэглэдэггүй | | | | |
| 7. | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Түүх, соёлын дурсгал байхгүй | | | | |
| 8. | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | Газрын маргаан болон давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагагүй | | | | |
| 9. | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Уул уурхайн төсөл биш учраас дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ байхгүй | | | | |
| 10. | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 |
| 11. | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах | 1800.0 | 5800.0 | 1800.0 | 5800.0 | 1800.0 |
| Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв | | 5200.0 | 7700.0 | 3300.0 | 7300.0 | 5300.0 |

БОМТөлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнд 2022-2026 онд нийт **28800.0** мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарсан байна.

8.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Тэрэлж лож” жуулчны баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтүүдийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээ төлөвлөх зорилгоор энэхүү хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ тогтоосон зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандан холбогдох арга хэмжээ авна.

Хүснэгт 26. Орчны хяналт шинжилгээ

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Байршил | Тоо, ш | Хугацаа, давтамж | Аргачилал | Зардал, мян.төг |
|------------|---|---|--------|------------------|---|-----------------|
| 1 | Худгийн усны химийн ерөнхий үзүүлэлт | Унд-ахуйн хэрэгцээний гүний худаг | 1 | Жилд 1 удаа | Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт. MNS 0900:2010 Усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх | 50.0 |
| 2 | Жуулчны баазын хөрсний бохирдлыг хянах | Хог хаягдлын цэг, барилгажааг үй сул талбай | 2 | Жилд 1 удаа | Ариун цэврийн тухай хууль Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850: 2008 | 100.0 |
| 3 | Жуулчны баазын үйл ажиллагааны үед гарч буй ахуйн шингэн хаягдлаас дээж авч | Бохирын цооногоос | 1 | Жилд 1 удаа | Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015 | 50.0 |
| Дүн | | | | | | 200.0 |

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар жилд 200.0 мян.төг зарцуулахаар байна. “Тэрэлж лож” жуулчны баазын төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 2022-2026 онд нийт 1000.0 мянган төгрөг зарцуулна.

ДҮГНЭЛТ

“Планет интернэшнл” ХХК-ийн Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэр, Горхи-Тэрэлжийн БЦГ-н Онгоцотын аманд хэрэгжүүлж буй “Тэрэлж лож” жуулчны баазын ТЭЗҮ, төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон төслийн БОННУ-ий тайлан боловсруулахад оролцсон шинжээчдийн судалгааны үр дүн, дүгнэлтийг нэгтгэн доорх санал зөвлөмжүүдийг мөрдөж ажилласан нөхцөлд энэхүү төслийг цаашид хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар тайланд өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллах;
- Энэхүү БОННУ-ий хүчинтэй байх хугацаанд (2022 он ... 2026 он) БОМТ-г мөрдөж ажиллах;
- Байгаль орчны аудитыг 2 жил тутамд нэг удаа, газрын төлөв байдал чанарын хянан баталгааг 5 жил тутамд 1 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- ТЖБОМТ-г БОАЖЯ-аар жил бүр батлуулж уг төлөвлөгөөний дагуу хийсэн ажлаа холбогдох ажлын хэсгээр дүгнүүлж байх
- Төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчны болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу шуурхай арга хэмжээ авч дутагдал зөрчлийг тухай бүрд нь арилгаж үр дүнг нь тайлагнаж байх зэрэг болно.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

1. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль УБ 2012 он
2. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын А-117 тоот тушаал Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачилсан заавар
3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлан, “Зууны кадастр” ХХК, 2018 он
4. Монгол Улсын “Газрын тухай” хууль. 2002
5. “Монгол орны хөрс” 2003 он, УБ. Доржготов Д.
6. “Монгол орны геотехникийн нөхцөл” УБ. 2009 он. Хууд 107-116. Дашжамц. Д нар.
7. “Тэрэлж лож” жуулчны баазын БОМТ биелэлтийн тайлан УБ. 2021 он
8. Хог хаягдлын тухай хууль, шинэчилсэн найруулга
9. Усны хэрэгцээг тооцоолох гарын авлага. БОНХЯ, Нидерландын вант улсын засгийн газар. Г. Долгорсүрэн PhD, Ч. Пунцагсүрэн PhD. 2012 он.
10. Буян-Орших Х. “Геоботаник, геоботаникийн судалгааны аргазүй” УБ., 2003.
11. Түвшинтогтох И. “Хээрийн ургамалжил” УБ., 2014.
12. MNS 3298-90. Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага.
13. MNS 5850: 2008. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
14. MNS 3297:1991. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ
15. MNS 3297:1991. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ
16. М1:100 000 масштабтай хөрс, ургамлын зураг (Тоон мэдээлэл)
17. <http://Agaar.mn>
18. <http://www.pmis.gov.mn>
19. <http://www.icc.mn>
20. www.tsag-uur.mn
21. <http://manaikhoroo.mn>
22. <http://tuv.nso.mn/>
23. <http://ubstat.mn>
24. Ulaanbaatar.maps.arcgis.com
25. <http://gorkhi-terelj.mpa.gov.mn>
26. <http://www.airquality.ub.gov.mn>
27. <http://www.mne.mn> (байгаль орчны мэдээллийн сан)